


НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИ 2040

giz

2023 оны 12-р сар

Just Energy Transition in Coal Regions



Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилтийн санаачлагын бүсүүд (“Innovation Regions for a Just Energy Transition” - IKI JET) төслийг Германы Эдийн засаг, Уур амьсгалын яам (BMWK), Олон улсын уур амьсгалын санаачлага (IKI) дор Европын Холбооны Олон улсын хамтын ажиллагааны ерөнхий захиргаа (DG INTPA)-ны хамтаар санхүүжүүлж Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) тэргүүтэй Олон Улсын Уур Амьсгалын Үйл Ажиллагааны Сүлжээ (CAN), Олон Улсын Тогтвортой Хөгжлийн Институт (IISD), Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO) болон Вупперталь Институт зэрэг хамтран хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилт бүс нутаг дундын платформ (JET-CR Platform) төсөл нь нүүрсэд суурилсан эрчим хүчний тогтолцооноос сэргээгдэх эрчим хүчний тогтолцоо руу нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг ханган шилжих боломжийг бүрдүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх зорилготой Колумб, Чил, Өмнөд Африк, Индонез, Вьетнам, Тайланд, Монгол улсад хэрэгжиж байна.

Төслийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын нэг болох Knowledge Hub (Мэдлэгийн төв) нь нүүрсэд суурилсан эрчим хүчний тогтолцооноос шилжиж буй бүс нутгуудын мэргэжилтнүүд, бодлого тодорхойлогчид, нүүрстэй хамаарал бүхий аж үйлдвэр, худалдааны нэгдэл болон иргэний нийгмийн байгууллагуудын гол төлөөлөгчид хооронд туршлага солилцох Европын Холбооны улс орнуудын туршлагаас хуваалцах, тус сэдвийн хүрээнд олж мэдсэн сургамж, цаашлаад орон нутгийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлсэн арга хэмжээг дэлхийн түвшинд хуваалцах, тодорхой мэдлэгийг хэрхэн ажил болгох гэх мэт хүрээнд мэдээлэл, санал шийдлүүдийг эрэлхийлэх боломжийг бүрдүүлэх зорилготой.

Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилтийн хүрээнд гарч буй судалгаа, шинжилгээ, мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх, үүнтэй холбоотой үйл ажиллагаа, арга хэмжээг мэдээлэх “нэг цэгийн үйлчилгээ” юм.

<https://www.jetknowledge.org/>

Supported by:



Federal Ministry
for Economic Affairs
and Climate Action



INTERNATIONAL
CLIMATE
INITIATIVE



Co-funded by
the European Union

on the basis of a decision
by the German Bundestag

Тус нийтлэлийг Германы Эдийн засаг, Уур амьсгалын яамны Олон улсын уур амьсгалын санаачлага (IKI) болон Европын Холбооны Олон улсын хамтын ажиллагааны ерөнхий захиргаа (DG INTPA) санхүүжүүлсэн болно. Нийтлэлийн агуулга нь дан ганц зохиогчдын хариуцлага бөгөөд Германы Эдийн засаг, Уур амьсгалын яам, Европын Холбоо болон Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн байр суурь тусгагдаагүй болно.

Энэхүү хэвлэл нь дараах лицензийн дагуу олгогдсон: [Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License](https://creativecommons.org/licenses/by-nc-sa/4.0/).

Зураг: Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн алба

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) - ийн тухай

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) нь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн туслалцааны үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага юм.

(GIZ) нь Германы засгийн газарт дэмжлэг үзүүлдэг ашгийн бус байгууллага бөгөөд нийтийн болон хувийн хэвшлийн салбаруудтай хамтран эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт гэх мэт олон салбаруудад эрчим хүч, байгал орчин, энх тайван аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Тус зорилгын хүрээнд (GIZ) нь түнштэйгээ хамтын ажиллагаа бий болгож нийгмийн сайн сайхан, тогтвортой байдлын төлөөх үр дүнтэй шийдлүүдийг гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

Төв оффис

Германы Олон Улсын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)
Фридрих-Эберт-Аллее 32 +
36
53113 Бонн хот, Герман улс
www.giz.de

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилтийн инновацийн бүсүүд (IKI JET) төсөл (2022-2027) нь дэлхийн нүүрснээс хамааралтай зарим бүс нутгуудад хоцрогдсон нүүрсэн дээр суурилсан эрчим хүчний системээс тэг ялгарал болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эрчим хүчний системд шилжих шилжилтийг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Түүнчлэн нүүрснээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын зэрэгцээ бүх талын оролцоог хангасан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд зохистой ажлын байр, нийгмийн баталгааг бий болгох чиглэлээр шилжилтийг дэмжиж, эрчимжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын Налайх дүүрэг нь эрчим хүчний зохистой шилжилтийг эхлүүлэх дэлхийн хэмжээнд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх түүхэн боломж бүхий 7 орны нэгээр сонгогдсон юм.

Нөхцөл байдлын шинжилгээ. Налайх дүүрэг нь нүүрсний уурхайд түшиглэн хөгжиж ирсэн бөгөөд 1990 онд гарсан ноцтой ослын улмаас 70 жил үйл ажиллагаа явуулсан Налайхын Их уурхай хаагдсан ч 2019 он хүртэл хувь хүмүүс бичил олборлолт явуулж байсан бөгөөд дүүргийн эдийн засаг, ажил эрхлэлт нь уул уурхайгаас ихээхэн хамааралтай байв. Нүүрсний уурхай хаагдсанаар тухайн үед ажиллаж байсан 1500-2500 уурхайчид ажилгүй болсон. Нийт 338 га газар нүүрсний их уурхай болон бичил уурхайн олборлолтод өртөж хөндөгдсөн байна. Хот, дүүргийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 140 га газарт нөхөн сэргээлт хийгдсэн ч үлдсэн 198 га газрыг нөхөн сэргээх шаардлагатай хэвээр байна. Нөхөн сэргээлт хийсний дараа энэ газрыг ногоон байгууламж, сэргээгдэх эрчим хүчний газруудад ашиглах боломжтой. Тус дүүргийн эдийн засгийн гол салбарууд нь одоогийн байдлаар аж үйлдвэр, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт болон аялал жуулчлал юм. Гэтэл улс болон нийслэлээс төсвийн татаас авдаг 2 дүүргийн нэг нь Налайх дүүрэг юм. 2023 онд Налайх дүүргийн төсвийн 24 хувийг төрөөс татаас хэлбэрээр авсан. Дүүргийн нийт төсвийн 9 хүрэхгүй хувийг хөрөнгө оруулалтын ажилд зориулав. Харин Налайх дүүрэгт аялал жуулчлал, хөдөө аж ахуй, ложистик, аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгаа төрөлжүүлэх бүрэн боломжтой. Налайх дүүргийн өнөөгийн эрчим хүчний систем бүхэлдээ нүүрсээр эрчим хүч үйлдвэрлэхэд тулгуурласан. Өрхийн 30 орчим хувь нь Налайхын дулааны станцад холбогдсон бол үлдсэн 70 хувь нь өрхийн зууханд сайжруулсан түлшээр халаалтаа шийдэж байна. Нийт айл өрхийн 98 хувь нь цахилгаан сүлжээнд холбогдсон. Одоо байгаа дэд бүтэц хуучирсан, шинэ бүтээн байгуулалтыг даах хүчин чадал хангалтгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн чиглэлээр санаачилга гарч байгаа ч хэтэрхий жижиг байгаа ба томоохон хөрөнгө оруулалт, дэмжлэг шаардлагатай байна. Тиймээс орон нутгийн засаг захиргаа эрчим хүчний салбар болон бусад сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг эрчим хүчний салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Шинэ ажлын байр бий болгох, уурхайчдыг сургаж, ажиллуулах боломжтой хэд

хэдэн аж үйлдвэрийн бүтээн байгуулалт, нийгэм эдийн засгийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хууль, бодлогын баримт бичгийн шинжилгээ Судалгааны хүрээнд хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг хянаж, дүн шинжилгээ хийсэн. JET-ийн үйл ажиллагааг орон нутаг, эрчим хүч, төсөв, бодлогын чиглэлээр зохицуулсан үндсэн 7 хуулийг хянаж, дүн шинжилгээ хийлээ. Эдийн засгийн салбар, эрчим хүч, уул уурхай, хөдөлмөр эрхлэлт, хот төлөвлөлт, дэд бүтэц гэсэн JET-ийн сэдэвчилсэн бодлогын баримт бичгүүдийг улс, орон нутаг, салбар, дүүргийн түвшинд авч үзэж, дүн шинжилгээ хийлээ.

Дүүргийн Засаг дарга нь улс орны урт, дунд хугацааны бодлого, нийслэлийн дунд хугацааны бодлоготой уялдуулан дүүргийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж байгаа нь хууль эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээнээс харагдаж байна. Дүүргүүд нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу дүүргийн хэмжээнд хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгийн менежмент, нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн ашиглалт, төсөв, хот тохижилтын ажил, авто замын шинэчлэлт, хог хаягдлын менежмент болон бусад чиглэлээр тодорхойлон хэрэгжүүлэх болон удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэгтэй. Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу дүүргийн Засаг даргад дүүргийн эрчим хүчний хангамж, эрчим хүчний хэмнэлтийн талаар баримтлах бодлого боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгосон. Мөн Засаг дарга сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх болон иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх үүрэгтэй.

Бодлогын баримт бичгийн үнэлгээнд үндэсний дөрвөн бодлогын баримт бичиг, нэг салбарын баримт бичиг, хотын зургаан баримт бичиг, дүүргийн дөрвөн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Үндэсний болон салбарын баримт бичиг нь үндэсний болон хотын түвшинд JET-ийн сэдэвчилсэн чиглэлийг уялуулан авч үзсэн бөгөөд JET-ийн зарим үйл ажиллагаа нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхүйц ажлууд байдаг. Налайх дүүргийн хөгжлийн төлөвлөлт нь хот, дүүргийн бодлогын баримт бичигт туссан байх бөгөөд JET-тэй холбогдох олон хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөгдсөн байна.

Оролцогч талуудтай хийсэн уулзалтын үр дүн 2023 оны 10-р сарын 11-16-ны хооронд төрийн байгууллагууд болон оролцогч талууд, иргэдтэй фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Оролцогч талуудын уулзалтын зорилго нь i) дүүргийн хэмжээнд JET хэмжигдэхүүнтэй холбоотой тулгамдаж буй гол асуудлуудыг олж харах, хэлэлцэх ii) орон нутагт хийгдэж буй үйл ажиллагааг тодруулах, iii) JET-ийг хэрэгжүүлэх цаашдын боломжит арга замыг хэлэлцэх явдал байв. Төрийн талаас оролцогч талууд болох Налайх дүүргийн Засаг дарга, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Дулааны станц, Барилгын материалын үйлдвэр технологийн парк, Тавантолгой түлш ТӨХК-ийн Зүүн бүсийн үйлдвэр, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний Хэрэглэгчдэд үйлчлэх төв зэрэг

байгууллагууд оролцсон. 2023 оны 10 дугаар сарын 9-нөөс 15-ны хооронд дөрвөн фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд иргэдтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн зорилго нь (i) гэр хорооллын дулаан хангамжийн тулгамдсан асуудлууд (ii) сайжруулсан түлшний давуу болон сул талууд (iii) сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигладаг айл өрхийн өнөөгийн байдал (iv) уурхай хаагдсаны дараа уурхайн ажилчдын хөдөлмөр эрхлэлт зэрэг сэдвүүдийг тойрч ярилцав. Фокус бүлгийн ярилцлагад 5-12 иргэдийг хамруулсан. Налайх дүүргийн 281 иргэнээс 2023 оны 10 дугаар сарын 02-08-ны хооронд гэр хорооллын халаалтын шийдэл, түлшний хэрэглээ, цаашдын шилжилтийн боломжуудыг тодорхойлох судалгааг авсан.

Оролцогч талуудын уулзалтаас гарсан гол дүгнэлтүүд нь: (i) дүүрэг дулаан хангамжийн томоохон хомсдолтой бөгөөд өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүй байна (ii) төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх санхүүжилтийн эх үүсвэр дутмаг (iii) шинэ дулааны цахилгаан станцыг барьж, эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг бүх түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна (iv) сэргээгдэх эрчим хүч болон бусад салбарт ажиллах хүч гаргаж, бэлтгэх шаардлагатай (v) Налайхын Барилгын материалын үйлдвэр технологийн парк болон Тавантолгой түлшний үйлдвэрүүд нь орон нутгийн иргэдэд ажлын байр бий болгоно (vi) орон нутгийн засаг захиргаа ЖЕТ-ийг дэмжиж, ЖЕТ стратеги, хэрэгжилтийг хэлэлцэхэд бэлэн байгаа нь харагдсан. Фокус бүлгийн ярилцлага, санал асуулгын гол үр дүн нь: (i) хуучин уурхайчид шинэ ажил олоход бэрхшээлтэй хэвээр байна (ii) тэдэнд илүү их ажлын байр, зохистой цалин хэрэгтэй байна (iii) нөхөн сэргээлтийн ажилд оролцох хүсэлтэй байна (iv) сайжруулсан нүүрсний чанар муу, тиймээс тэд Налайхын түүхий нүүрсийг дахин ашиглахад бэлэн байна (v) эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний ашиг тусыг мэддэг боловч санхүүгийн бэрхшээлээс болоод гэр байшингаа дулаалж чадахгүй байна. (vi) цахилгаан халаагуур ашигладаг боловч цахилгааны зардал өндөр байна (vii) дэд бүтцийн хангамжийн төсөл хойшлогдож байгаа ч, орон сууцны нөхцөлөө сайжруулж, дэд бүтцэд холбогдох бэлэн байна.

Налайх дүүрэгт хэрэгжүүлэх ЖЕТ (Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилт) стратегийг боловсруулах. Нөхцөл байдлын шинжилгээ, хууль эрх зүй, бодлогын шинжилгээ, оролцогч талуудтай хийсэн уулзалтуудад үндэслэн Налайх дүүргийн Эрчим хүчний зохистой шилжилтийн стратегийг боловсрууллаа. Эрчим хүчний зохистой шилжилтийн стратеги нь ЖЕТ-ийн үндсэн чиглэлүүд, Налайх дүүргийн онцлогт нийцүүлэн тусгагдсан болно. Үүнд: i) эдийн засгийг төрөлжүүлэх, сэргээх, ii) нүүрсний уурхайн нөхөн сэргээлт ба шинэ бүтээн байгуулалт, iii) ногоон, зохистой ажлын байр, нийгмийн хамгаалал, iv) нүүрсэнд суурилсан эрчим хүчний системээс нүүрстөрөгч багатай эрчим хүчний системд шилжих, v) ЖЕТ стратеги болон түншлэл. Налайх дүүргийн ЖЕТ стратегийн зорилт нь 2040 он гэхэд хоцрогдсон, нүүрсэнд суурилсан эрчим хүчний системээс уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний системд шилжихэд чиглэж байгаа бөгөөд стратегийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн таван үндсэн зорилтыг тусгасан. Түүнчлэн зорилт тус бүрээр санхүүжилтийн хувилбар бүхий

нарийвчилсан стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан. Шалгуур үзүүлэлтүүдийн суурь оныг 2022 оноор авч хүлээгдэж буй зорилтот онуудтай харьцуулах байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан. Стратегийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг стратегид тодорхойлсон. 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, дүүргийн нийгэм эдийн засгийг 2024 он хүртэл хөгжүүлэх нэг жилийн төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөсөн.

JET стратегийг Налайх дүүргийн Засаг даргын зөвлөлд танилцуулах. Налайх дүүрэг нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрхзүйн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Налайх дүүргийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дүүргийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталдаг. Энэхүү стратеги нь хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ: i) Налайх дүүргийн Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2024 оны төлөвлөгөөнд тусгах Эрчим хүчний зохистой шилжилтийн нарийвчилсан төлөвлөгөө, ii) Налайх дүүргийн Эрчим хүчний зохистой шилжилтийн стратеги.

Стратеги болон нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэд хэдэн үе шаттайгаар хэлэлцэн батлах юм. 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон Эрчим хүчний зохистой шилжилтийн стратегийг i) Засаг даргын орлогчоор ахлуулсан ЗДТГ-ын хэлтсийн дарга нар, хөдөлмөр халамж, жижиг дунд үйлдвэр, эрчим хүч зэрэг холбогдох байгууллагууд, ii) Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нараас бүрдсэн Засаг даргын зөвлөлд тус тус танилцуулна. Дүүргийн Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд стратегийн төлөвлөгөөг тусгах ба стратегийн баримт бичгийг бүхэлд нь дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Агуулга

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	IV
I. ТАНИЛЦУУЛГА – ЖЕТ ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНҮҮД	1
II. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	3
2.1 Нийгэм, эдийн засгийн байдал	4
2.1.1 Хүн ам, өрх	4
2.1.2 Боловсролын түвшин ба хөдөлмөр эрхлэлт	4
2.1.3 Ядуурал, эмзэг бүлэг	5
2.1.4 Орон сууцны нөхцөл байдал	5
2.1.5 Эдийн засгийн голлох салбар	5
2.1.6 Төсөв	5
2.1.7 Аж ахуйн нэгж, байгууллага	6
2.1.8 Нийгмийн хангамжийн үйлчилгээ	6
2.1.9 Тээвэр	6
2.2 Дэд бүтцийн байдал	7
2.2.1 Дулаан хангамж	7
2.2.1.1 Төвлөрсөн дулаан хангамжийн систем	7
2.2.1.2 Гэр хорооллын айл өрхийн халаалтын эх үүсвэр	8
2.2.2 Цахилгаан хангамж	8
2.2.3 Ус хангамж, ариутгах татуурга	8
2.2.4 Хог хаягдал	8
2.3 Уул уурхай, Үйлдвэр	9
2.3.1 Уул уурхай	9
2.3.1.1 Ашигт малтмал	9
2.3.1.2 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	9
2.3.1.3 Нүүрсний уурхай	9
2.3.2 Үйлдвэр	11
2.3.2.1 Тоосгоны үйлдвэр	11
2.3.2.2 Шахмал түлшний үйлдвэр	11
2.3.2.3 Хог боловсруулах үйлдвэр	12
2.4 Эрчим хүч, түлш	12
2.4.1 Эрчим хүч	12
2.4.1.1 Орон сууцны салбар	12

2.4.1.2 Аж ахуйн нэгж ба үйлдвэрлэлийн салбар	13
2.4.2 Түлш	13
2.4.3 Сэргээгдэх эрчим хүч	13
2.5 Тулгамдаж буй асуудал	14
2.5.1 Нийгэм, эдийн засгийн тулгамдаж буй асуудал	14
2.5.2 Дэд бүтцийн тулгамдаж буй асуудал	14
2.5.3 Уул уурхай, үйлдвэрийн тулгамдаж буй асуудал	15
2.5.4 Эрчим хүчний тулгамдаж буй асуудал	15
2.6 SWOT АНАЛИЗ	16
III. ҮЙЛ АЖИЛЛАГАА 2. ХУУЛЬ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ	19
3.1 Хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа	19
3.2 Бодлогын баримт бичгийн судалгаа	22
3.2.1 Үндэсний бодлогын баримт бичгийн судалгаа	23
3.2.2 Салбарын бодлогын баримт бичгийн судалгаа	25
3.2.3 Нийслэлийн бодлогын баримт бичгийн судалгаа	26
3.2.4 Дүүргийн бодлогын баримт бичгийн судалгаа	28
3.2.5 JET чиглэлүүдийн хүрээнд нийслэл, дүүргийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа	30
IV. НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИСТОЙ ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИ	38
4.1 Алсын ХАРАА	38
4.2 ЭРХЭМ ЗОРИЛГО	38
4.3 СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД	38
V. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	39
СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА	41
СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ	43
VI. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	45
СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН	45
СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	46

Зургийн жагсаалт

Зураг 1	Налайх дүүргийн байршил	3
Зураг 2	Налайх дүүргийн бүсчлэл, гол объектуудын байршил.....	3
Зураг 3	Дулааны станц болон дэд бүтэц	7
Зураг 4	Уурхайн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газрууд	10
Зураг 5	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр.....	12
Зураг 6	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр.....	13
Зураг 7	Бодлогын баримт бичиг.....	23

Хүснэгтүүдийн жагсаалт

Хүснэгт 1	СВОТ анализ	16
Хүснэгт 2	Холбогдох хууль эрх зүйн баримт бичигт JET-ийн салбаруудын талаар тусгагдсан байдал	19
Хүснэгт 3	Бодлогын баримт бичигт JET-ийн салбаруудын талаар тусгагдсан байдал.....	22
Хүснэгт 4	JET-ийн салбаруудын хүрээнд нийслэлийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа	30
Хүснэгт 5	JET салбаруудын хүрээнд Налайх дүүргийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа	33

I. ТАНИЛЦУУЛГА – JET Үндсэн хэмжигдэхүүнүүд

Орон нутгийн хэмжээнд нүүрсний шилжилт хийх JET-ийн үндсэн хэмжигдэхүүнүүд нь i) эдийн засгийг төрөлжүүлэх, хөгжүүлэх ii) ногоон, зохистой ажлын байр, нийгмийн хамгаалал iii) олон нийтэд түшиглэсэн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө iv) эрчим хүчний систем v) нүүрсний уурхайн хаалт, экологийн нөхөн сэргээлт, нүүрсний хөрөнгийн дахин ашиглалт, vi) JET стратеги ба оролцооны механизм зэрэг юм. Эдгээр бүх сэдэвчилсэн чиглэл дээр жендэрийн асуудлыг хамтад нь авч үздэг.

Налайх дүүргийн хууль бодлогын болон нөхцөл байдлын шинжилгээний дүгнэлтэд үндэслэн Налайх дүүргийн түвшинд JET-ийн сэдэвчилсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар нутагшуулж болно:

- **Эдийн засгийг төрөлжүүлэх, нөхөн сэргээх:** Налайх дүүрэг нь Налайхын нүүрсний уурхайг түшиглэн байгуулагдсан. Тус дүүргийн нийгэм эдийн засаг, ажил эрхлэлтэд нүүрсний уурхай голлох үүрэг гүйцэтгэсээр ирсэн ч нүүрсний уурхайн томоохон ослын улмаас нүүрсний уурхайн үйл ажиллагаа зогссон. Гэвч хууль бус олборлолт 2019 он хүртэл үргэлжилж, Засгийн газраас өрхийн хэрэглээнд түүхий нүүрс түлэхийг хориглосноор энэхүү ажиллагаа бүрэн зогссон. Тус дүүргийн эдийн засгийн гол салбарууд нь аж үйлдвэр, ашигт малтмал, аялал жуулчлал юм. Гэтэл улсын болон орон нутгаас татаас авдаг дүүргийн нэг нь Налайх дүүрэг. 2023 онд Налайх төсвийн 24 хувийг төрөөс татаас хэлбэрээр авсан. Дүүргийн нийт төсвийн 9 хүрэхгүй хувийг хөрөнгө оруулалтын ажилд зориулсан. Дүүргийн гол орлогыг татвараас бүрдүүлдэг бөгөөд гол зарлага нь орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зардал байдаг. Налайх дүүрэг нь аялал жуулчлал, хөдөө байна аж ахуй, ложистик, аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгаа төрөлжүүлэх бүрэн боломжтой.
- **Нүүрсний уурхайн нөхөн сэргээлт:** Налайхын уурхайн нүүрсний олборлолт нь 1922 оноос хойш 70 гаруй жил үйл ажиллагаа явуулсан Монгол улсын анхны уул уурхай, аж үйлдвэр бөгөөд 2019 оноос хойш нүүрс олборлолт бүрэн зогссон. Нийт 338 га талбай нүүрс олборлолт, бичил уурхайн үйл ажиллагаанд өртөж хөндөгдсөн бөгөөд 2017 оны судалгаагаар нөхөн сэргээлтэд 7.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа аж. Одоогоор нийслэл, дүүргийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 140 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. Үлдсэн 198 га талбайг нөхөн сэргээх шаардлагатай хэвээр байна. Нөхөн сэргээлтийн дараа тухайн талбайг ногоон байгууламж, сэргээгдэх эрчим хүчний объектуудад ашиглах боломжтой гэдгийг нарийвчилсан судалгаа харуулж байна. Цаашид энэхүү газрын талаар хөгжлийн нэгдсэн төлөвлөлт хийх шаардлагатай байна.
- **Ногоон, зохистой ажлын байр, нийгмийн хамгаалал:** Нүүрс олборлолт нь Налайхчуудын албан болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн гол салбар байсан.

Налайхын уурхайгаас олборлосон нүүрсээр Улаанбаатар хотын бүх хэрэгцээг хангаж, нэг дор 1500 хүртэл хүнийг ажлын байраар хангадаг байв. Зарим гэр бүлүүд үе дамжин нүүрсний уурхайд ажилладаг байв. Статистикийн мэдээгээр 2018 онд нийт ажиллах хүчний 13 орчим хувь нь нүүрс олборлолтод ажиллаж байсан бол албан ёсоор хаагдсаны дараа 2019 он хүртэл 2500 орчим хүн хууль бусаар нүүрс олборлох ажил хийдэг байв. 2020 онд дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн судалгаа хийсэн. Судалгааны үндсэн дээр Налайх дүүрэгт 2020-2024 оны хооронд инновацид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зохистой ажлын байр бий болгох, ажилгүйдлийн түвшинг бууруулах, ажлын байр бий болгох замаар дүүргийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийг боловсруулсан. Шинээр ажлын байр бий болгох, уурхайчдыг сургаж, ажиллуулах боломжтой хэд хэдэн аж үйлдвэрийн бүтээн байгуулалт, нийгэм эдийн засгийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

- **Нүүрсэнд суурилсан эрчим хүчний системээс нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний системд шилжих:** Өнөөгийн Налайх дүүргийн эрчим хүчний систем бүхэлдээ нүүрсэнд суурилсан эрчим хүч үйлдвэрлэхэд суурилж байна. Өрхийн 30 орчим хувь нь Налайхын дулааны станцад холбогдсон бол үлдсэн 70 хувь нь сайжруулсан нүүрс түлдэг өрхийн зуухаар халаалтаа шийдэж байна. Нийт айл өрхийн 98 хувь нь цахилгаан сүлжээнд холбогдсон. Одоо байгаа дэд бүтэц хуучирсан, шинэ бүтээн байгуулалтыг даах хүчин чадал хангалтгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн чиглэлээр санаачилга гарч байгаа ч хангалтгүй бөгөөд томоохон хөрөнгө оруулалт, дэмжлэг шаардлагатай байна. Тиймээс орон нутгийн засаг захиргаа эрчим хүчний салбар болон бусад сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг эрчим хүчний салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж байна.
- **JET стратеги ба түншлэл:** Налайх дүүрэг JET-ын үйл ажиллагаатай холбоотой дунд хугацааны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Дулааны ерөнхий төлөвлөгөө, Хэсэгчилсэн мастер төлөвлөгөө, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр гэх мэт хэд хэдэн хөтөлбөр, төслийг баталж, хэрэгжүүлж байна. “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу дүүргийн Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг төрөөс баримтлах урт, дунд хугацааны бодлого, нийслэлийн дунд хугацааны бодлогын хүрээнд дүүргийн Засаг дарга нар боловсруулдаг. Иймд JET стратегийг хуулийн холбогдох заалтыг баримталж, дүүргийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл болгон боловсрууллаа. Стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт багтаан батлуулахаар бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн боловсруулсан. Ингэснээр JET стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох төрийн байгууллагууд болон төрийн бус оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлэх боломжтой.

II. Нөхцөл байдлын шинжилгээ


Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь зургаан төвийн дүүрэг, гурван алслагдсан дүүрэгтэй (Зураг 1). Налайх дүүрэг нь Улаанбаатар хотын төв цэгээс зүүн урагш зүгт 36 км зайд оршдог алслагдсан дүүрэг юм. Налайх дүүрэг нь Налайхын уурхайг түшиглэн 1962 онд Налайх хот, Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу 1992 онд Налайх дүүрэг болжээ. Цаг агаарын хувьд өвөлдөө цельсийн -20-25 хэм, зундаа +23+26 хэмийн дундаж агаарын температуртай. Тус дүүрэг нь 68,800 га газар нутагтай бөгөөд засаг захиргааны 8 хороотой. Газар нутгийнх нь 48% нь Горхи-Тэрэлжийн тусгай хамгаалалттай газар, 24% нь хөдөө аж ахуй, газар тариалангийн газар, 10% нь ашигт малтмалын орд газар, 10%-ийг төрийн тусгай зориулалтын газар, 8%-ийг хот суурин газар эзэлж байна.

Зураг 1 Налайх дүүргийн байршил



Эх сурвалж: Зохиогчийн зураг

Зураг 2 Налайх дүүргийн бүсчлэл, гол объектуудын байршил



Эх сурвалж: Зохиогчийн зураг

2.1 Нийгэм, эдийн засгийн байдал

Налайх дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын ажил эрхлэлт зэрэг нь нүүрсний уурхайн үйл ажиллагаатай салшгүй холбоотой байсаар ирсэн.

2.1.1 Хүн ам, өрх

2022 оны байдлаар Налайх дүүрэгт 10,510 өрхийн 39,600 хүн оршин сууж байна. Хүн ам 2000-2010 онд 3.5%-иар, 2010-2022 онд 2.6%-иар өссөн байна. Энэ нь нийслэлийн дундажтай харьцуулахад 2.4 дахин бага байна. Хүн амын 49.7% нь эрэгтэйчүүд, 50.3% нь эмэгтэйчүүд байна. Насны бүтцийн хувьд хүн амын 33% нь 0-14 нас, 14% нь 15-24 нас, 40% нь 25-54 нас, 12% нь 55 ба түүнээс дээш насны бүлэгт хамаарагдаж байна. Нийт өрхийн 29% нь 1-2 ам бүлтэй өрх, 38% нь 3-4 ам бүлтэй өрх, 25% нь 5-6 ам бүлтэй өрх, 8% нь 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх байна.

2.1.2 Боловсролын түвшин ба хөдөлмөр эрхлэлт

Хүн амын боловсролын түвшний үзүүлэлтээр 10 ба түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын байдал 95%-тай байгаа нь нийслэлийн бусад дүүргүүдтэй харьцуулахад хамгийн бага байна. Боловсрол эзэмшсэн иргэдийн 46% нь эмэгтэйчүүд байна. Техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн их буюу 8.6% байна.

2022 оны байдлаар дүүргийн хэмжээнд ажиллах хүч 11,350 хүн байна. Ажиллах хүчийг 2010 оныхтой харьцуулахад 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ажиллах хүчний 42%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүтцийн хувьд ажиллах хүчний 21%-ийг 15-29 нас, 76%-ийг 30-54 нас, 3%-ийг 55-59 насны хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн ердөө 34%, эрэгтэйчүүдийн 51% нь хөдөлмөр эрхэлж байна. Ялангуяа 20-39 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин дундажаар 39% нь байгаа нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин бага байна. Харин 40-54 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин харьцангуй өндөр буюу дундажаар 68% байна. Дүүргийн хэмжээнд 226 бүртгэлтэй ажилгүй иргэд байгаагийн 48.2% нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр үзвэл нийт ажилгүй иргэдийн 26% нь 15-24 насны залуучууд, 36% нь 25-34 насныхан, 23% нь 35-44 насныхан, 12% нь 45-54 насныхан, 3% нь 55-аас дээш насныхан байна.

2018 онд дүүргийн нийт ажиллагчдын 50 гаруй хувь нь хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байсан байна. 2018 онд дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56% байсан бол 42% болж буурсан байна. Энэ нь 2019 оны бичил уурхайг хаасантай үүдэлтэй байх боломжтой юм. Дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн дэлгэрэнгүй судалгааг 2022 оны түвшинд гаргаагүй байна.

2.1.3 Ядуурал, эмзэг бүлэг

Налайх дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй нийт 1,566 хүн байгаа нь нийт хүн амын 4.2%-ийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 40% нь эмэгтэйчүүд байна. 2011 оны байдлаар Налайх дүүргийн ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшин 46.8% байсан нь нийслэлийн үзүүлэлтээс 2 дахин их байжээ.

2.1.4 Орон сууцны нөхцөл байдал

2022 оны байдлаар Налайх дүүрэгт 10,510 өрх оршин сууц байгаагийн 28 хувь нь нийтийн орон сууцанд, 72% нь гэр хороололд буюу түүний 34% нь амины орон сууцанд, 38% нь гэр сууцанд амьдарч байна. Налайх дүүргийн 32 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах шийдвэр гарсан.

2.1.5 Эдийн засгийн голлох салбар

Налайх дүүргийн эдийн засгийн голлох салбарууд нь аж үйлдвэр, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, аялал жуулчлал юм. Налайх дүүргийн эдийн засагт хөдөө аж ахуй, газар тариалангийн эзлэх хэмжээ харьцангуй бага байна. Дүүргийн хэмжээнд 2022 онд 764 малтай өрх, 247 газар тариалан эрхэлдэг өрх бүртгэлтэй байна.

Налайх дүүргийн аж үйлдвэрийн гол бүтээгдэхүүн нь эрчим хүч, шохой, хайрга, элс, барилгын материал (тоосго, цемент, бетон зуурмаг, хэвлэлийн будаг гэх мэт), мах махан бүтээгдэхүүн зэрэг байна. Үүнээс хамгийн их эдийн засгийн ашиг өгч байгаа нь цахилгаан (192.8 сая.квт.цаг буюу 36243.9 сая төгрөг), дулааны (97.5 мян.ккал буюу 4 227.9 сая төгрөг) эрчим хүч, цемент (29.2 мян.тонн буюу 5 666.1 сая төгрөг), тоосго (5 564.6 мянган ширхэг буюу 1 383.8 сая төгрөг), бетон зуурмаг (9.0 мянган тн буюу 2 093.5 сая төгрөг), аюултай хог хаягдал зайлуулалт (1017.8 тонн буюу 1 396.4 сая төгрөг), мах (779.2 тонн буюу 6409.8 сая төгрөг) зэрэг бүтээгдэхүүн байна.

Аялал жуулчлал: Дотоод, гадаадын жуулчдын аялал жуулчлалын гол бүс болох Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт 180 орчим жуулчны бааз, 35 амралтын газар байдаг. Түүнчлэн дүүргийн нутаг дэвсгэрт Их эзэн Чингис хааны хөшөө, эртний Түрэгийн үеийн археологийн дурсгалт газрууд, Аръяабал хийд, 100 ламын агуй, Мэлхий хад, Гандан уул, Туул голын ай сав, Тэрэлж зэрэг түүх, байгалийн болон үзвэрийн газрууд байдаг.

2.1.6 Төсөв

2022 онд Налайх дүүргийн төсвийн орлого 10.9 тэрбум төгрөг байсан бол зарлага нь 16 тэрбум төгрөг буюу орлогоос 1.5 дахин их төсвийн алдагдалтай байна. Тус онд төсвийн нийт орлогын 91%-ийг татварын орлого, 9%-ийг татварын бус орлого бүрдүүлжээ. 2021-2022 онд улсын төсвийн 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус дүүрэгт 14 төсөл, арга хэмжээ, нийслэлийн төсвийн 38 тэрбум төгрөгөөр 14 төсөл, арга хэмжээг санхүүжүүлжээ.

2023 оны төсвийн тодотголоор дүүргийн төсвийн орлого 13.2 тэрбум төгрөг, зарлага 20.1 тэрбум төгрөг байна. Дүүргийн төсвийн орлогын 91%-ийг татварын орлого, 9%-ийг татварын бус орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн. Дүүргийн зарлага нь дүүргийн удирдлага, захиргааны байгууллагын урсгал зардал, сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, соёлын үйл ажиллагаа, түлш, халаалтын үнийн зөрүү, дүүргийн тохижилт, үйлчилгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон халамжийн байгууллагуудын урсгал зардлаас бүрдэж байна. Нийслэлийн төсвөөс дүүрэгт 4.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, дүүргийн өмнөх оны төсвийн үлдэгдэл 2 тэрбум төгрөг байна. Дүүргийн нийт төсвийн 8.6%-ийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулж байна. Тус хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд авто зам, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах, тохижилтын ажил, тоног төхөөрөмж, материал авах, сургууль, цэцэрлэгийн хангамж болон зарим айлуудыг цахилгаанд холбох зэрэг 67 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2.1.7 Аж ахуйн нэгж, байгууллага

2022 оны байдлаар Налайх дүүрэгт 1,700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ) бүртгэгдсэнээс 37% нь буюу 630 ААНБ үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо нь сүүлийн 10 жилийн хугацаанд 2.4 дахин өссөн. 2022 оны байдлаар бүртгэлтэй ААНБ-ын 84% нь 1-9 ажилтан, 13% нь 10-49 ажилтан, 3% нь 50-аас их ажилтантай байна. Хариуцлагын хэлбэрээр үзвэл дийлэнх буюу 68% нь ХХК, 11% нь салбар байгууллага, 10% нь төрийн бус байгууллага, үлдсэн 11% нь бусад төрлийн байгууллагууд байна.

2.1.8 Нийгмийн хангамжийн үйлчилгээ

Налайх дүүрэгт 2022 оны байдлаар 15 цэцэрлэг, 9 ерөнхий боловсролын сургууль, 1 техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллага, 1 их сургууль тус тус үйл ажиллагаа явуулж байна. Өмчийн хэлбэрийн хувьд 13 цэцэрлэг, 6 сургууль нь төрийн өмчийнх байна. Хүний нөөцийн хувьд цэцэрлэгт нийт 545, сургуульд 645 ажиллагчид ажиллаж байна.

Налайх дүүрэг нь нэгдсэн эрүүл мэндийн төв болон 4 өрхийн эрүүл мэндийн төвтэй. Нэгдсэн эмнэлэг нь төрөх тасаг, хүүхдийн эмнэлэг, халдварт, сэргээн засах, амбулатори гэсэн 5 үндсэн барилгатай бөгөөд тэдгээр нь 40 ба түүнээс дээш жилийн насжилттай байна. Нэгдсэн эмнэлэгт 326, өрхийн эмнэлэгт 56 нийтдээ эрүүл мэндийн салбарт 382 эмч, ажилтан ажиллаж байна.

2.1.9 Тээвэр

2022 онд Налайх дүүрэгт бүртгэгдсэн нийт 5,730 тээврийн хэрэгслийн 96%-ийг хувийн тээврийн хэрэгсэл эзэлж байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 4,585 (80%) суудлын автомашин эзэлж байгаа бол 1,006 (17.6%) нь ачааны, 95

(1.6%) автобус, 44 (0.8%) хувь нь тусгай зориулалтын автомашин байна. Дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн ихэнх буюу 93.5 хувийг 10-аас дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 9 жилийн хугацаанд буюу 2013-2022 онд 19.4%-иар өсжээ. Үүнийг тээврийн хэрэгслийн төрлөөр үзвэл суудлын автомашин 27.5%-иар өссөн байна.

2.2 Дэд бүтцийн байдал

2.2.1 Дулаан хангамж


2.2.1.1 Төвлөрсөн дулаан хангамжийн систем

Налайх дүүргийн дулааны гол эх үүсвэр болох дулааны станц нь 69Мвт-ийн хүчин чадалтай бөгөөд 7 дулаан хуваарилах төв, 3.4 км дулааны төв шугамаар хэрэглэгчдэд дулааны эрчим хүч түгээж байна. Тус дулааны станц нь 1976 онд ашиглалтад орсон.

Тус станц нь жилдээ 97-99 мян.гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, 4,057 сая төгрөгийн борлуулалт хийж байна. Тус станц нь дүүргийн 33 төсөвт байгууллага, 330 ААНБ, 2,840 (нийт өрхийн 26%) айл өрхийг халаалт болон хэрэгцээний халуун усаар хангаж байна.

Дүүргийн 5-р хороо буюу Городок тосгонд 11 аж ахуйн нэгж байгууллага болон 720 өрхийг дулаанаар хангадаг 7.6 Гкал/ц чадалтай, усан халаалтын 7 зуух байна. Үүнээс 5 зуух нь бэлтгэлд, 2 нь байнгын ажиллагаанд ажиллаж байна. Өмнө нь мазутаар ажиллуулдаг байсан бол 2000 оноос хатуу түлшинд шилжсэн. 1356м урттай цэвэр ус болон дулааны шугамтай, 19 худагтайгаар ажиллаж байна.

Зураг 3 Дулааны станц болон дэд бүтэц



Эх сурвалж: Зохиогчийн зураг

2.2.1.2 Гэр хорооллын айл өрхийн халаалтын эх үүсвэр

Гэр хорооллын айл өрхүүд нь төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдоогүй бие даасан халаалтын зуухаар дулааны эрчим хүчний хэрэглээгээ хангаж байна. Дүүргийн хэмжээнд нийт 7,600 айл өрхийн зуух байгаагаас 76% нь ердийн зуух, 24% нь сайжруулсан зуух байна. Айл өрхүүд өнгөрсөн 2022-2023 онд шилжих өвөл 12,500 тн сайжруулсан түлш хэрэглэж байна.

2.2.2 Цахилгаан хангамж

Налайх дүүрэг нь 110 кВ 25 км ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай Налайх дэд станц, мөн нийслэлийн шахмал түлшний үйлдвэрийг цахилгаанаар хангах 110/10-ын кВ 2х16 МВА чадалтай дэд станцуудтай. 2020 оны байдлаар дүүргийн цахилгааны ачаалал 14.5 МВт, цахилгааны хэрэглээ 65.4 сая.кВт.ц байсан бол 2023 оны байдлаар дүүргийн цахилгааны ачаалал 32 МВт, цахилгааны хэрэглээ 192.9 сая.кВт.ц болж өсөөд байна. Үүний 49%-ийг үйлдвэрийн зориулалтаар, 15%-ийг орон сууцны зориулалтаар, 36%-ийг гэр хорооллын айл өрхүүд түгээсэн.

Цахилгаан хангамжийн хувьд 98.4% нь төвлөрсөн цахилгааны системд холбогдсон, 0.7% нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашигладаг, үлдсэн 0.9% нь бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг. Цахилгаан эрчим хүчний хүчдэлийн уналттай 200 орчим айл өрх байна.

2.2.3 Ус хангамж, ариутгах татуурга

Налайх дүүрэг нь Улаанбаатар хотын цэвэр усны төв шугамаас усаа хангаж байна. Тус дүүргийн орон сууцны байрны 40% нь 60-70 жилийн насжилттай бөгөөд хэрэгцээний халуун усны системд холбогдоогүй байна. Ус хангамжийн хувьд нийт өрхийн 25% нь төвлөрсөн болон бие даасан систем, 61% нь худаг, 14% нь зөөврийн ус, савласан ус гэх мэт бусад эх үүсвэрээр ус хангамжаа шийдэж байна. Дүүргийн хэрэглээнээс гарсан бохир усыг Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид 2015 оноос хойш нийлүүлж байна. Нийт ариутгах татуургын шугам сүлжээний 70 хувь нь насжилт өндөр, ачаалал ихтэй байна. Налайх дүүргийн Городок тосгонд 1000м³-ийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна. Гэр хороололд оршин сууж байгаа өрхийн 97% нь энгийн нүхэн жорлон, үлдсэн хувь нь сайжруулсан, био жорлон гэх мэт ариун цэврийн байгууламжтай байна.

2.2.4 Хог хаягдал

Хог хаягдал зайлуулалтын 97%-ийг үйлчилгээний байгууллагаар, үлдсэн хувийг зөвшөөрөгдсөн цэгт хаях, шатаах, булах зэргээр зайлуулж байна.

2.3 Уул уурхай, Үйлдвэр

2.3.1 Уул уурхай

2.3.1.1 Ашигт малтмал

Налайх дүүрэг нь 130 сая жилийн өмнө үүссэн нүүрсний орд газартай.

2.3.1.2 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл


2023 оны байдлаар Налайх дүүргийн нийт газар нутгийн 10% буюу 7,300 орчим га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүний 46%-ийг уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл, 24%-ийг түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл, 30%-ийг түгээмэл тархацтай ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл тус тус эзэлж байна.

2.3.1.3 Нүүрсний уурхай

Налайхын нүүрсний уурхай нь 1910 оноос анх нүүрс олборлож эхэлснээс үүдэлтэй бөгөөд 1922 онд улсын үйлдвэр болгож, 1954-1958 онд Налайхын их уурхайг байгуулсан. Гэвч 1990 онд метаний хийн тэсрэлтээс үүдсэн томоохон хэмжээний осол болон түүнээс хойш гарсан хэд хэдэн ослоос шалтгаалан 1995 онд Налайхын их уурхайг хааж, үйл ажиллагааг нь зогсоосон. Их уурхай нь 1,600 ажилтантай, жилдээ 600,000 тн нүүрс олборлох хүчин чадалтай байсан. Тус уурхай нь 70 гаруй жил дангаараа нийслэлийг нүүрсээр хангасан ба дүүргийн эдийн засгийн хөгжил, иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр, улсын түлш хангамжийн гол эх үүсвэрийн нэг байсан.

Уурхай хаагдсанаас хойш хяналтгүйгээр гар аргаар нүүрс олборлодог иргэд бий болж 180 гаруй уурхайн цооногт 2,500 гаруй иргэд нүүрс олборлолт хийж байсан. Үүнийг зохицуулахын тулд 2017 онд Засгийн газрын тогтоол гаргаж иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулсан. Гэвч уурхайн ослоос болж амь насаа алдах, хөдөлмөрийн чадамжаа алдсан иргэдийн тоо буурахгүй байсан бөгөөд 2000-2018 онд 520 гаруй ослын дуудлагаар 512 хүнийг аварч, 214 хүн амь насаа алдсан. Түүнчлэн бичил уурхайн улмаас 338 га талбай эвдрэлд орсон байна.

Зураг 4 Уурхайн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газрууд



Эх сурвалж: Зохиогчийн зураг

Дээрх шалтгаануудын улмаас Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолоор бичил уурхайн үйл ажиллагааг бүрэн зогсоосон. Мөн Засгийн газраас 2018 онд утаатай тэмцэж, түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай 62 дугаар тогтоолыг батлан гаргасан. Уг тогтоолоор Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, ААНБ-ыг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс

хэрэглэхийг хориглосон. Улмаар бичил уурхайгаас олборлосон нүүрсийг зарж борлуулах зах зээл бүхэлдээ хаалттай болсон.

Уурхайн улмаас газрын хэвлийд их хэмжээний эвдрэл, нүх, цооног үүсч нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдсон. Эдгээр хаягдсан нүх, цооногт хүн, мал унаж бэртэх, амь нас, эрүүл мэндээрээ хохирох тохиолдол гардаг. Мөн төмөр зам доогуур малталт явуулсан байснаас үүдэн нуралт, цөмрөлт үүсч цаашид ашиглах боломжгүй болсон. Зарим суурьшлын бүсийн газар доогуур мөн малталт хийснээс цөмрөлт, нуралт үүсэх эрсдэлтэй болсон байсан. Түүнээс гадна нүүрс ачихаар ирсэн машинууд нүх цооногт хог хаягдал асгаж байгаль орчныг ихээхэн бохирдуулсан. 2023 оны байдлаар нийт 140.3 га газрыг нөхөн сэргээсэн бөгөөд цаашид 197.7 га газрыг нөхөн сэргээх шаардлагатай байгаа.

2.3.2 Үйлдвэр

2.3.2.1 Тоосгоны үйлдвэр

Налайх дүүрэгт 20 гаруй тоосгоны үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэрүүд нь жилд нийтдээ 42 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 2022 онд 37.8 мянган ширхэг тоосго үйлдвэрлэжээ.

Эдгээр үйлдвэрүүд нь газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр, хог хаягдлын төлбөр төлөх үүрэгтэй. Гэвч 2017-2020 онд татвар төлвөл зохих 19 аж ахуйн нэгжийн 46% нь татвар төлсөн байна. Тус онд нийтдээ 18.2 сая төгрөгийг ус ашигласны төлбөрт, 7.2 сая төгрөгийг хог хаягдлын төлбөрт, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрт 202.4 сая төгрөг, 204.2 сая төгрөгийн газрын төлбөрт хураан авч татварт төвлөрүүлжээ.

2.3.2.2 Шахмал түлшний үйлдвэр

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агаарын бохирдлыг 80 хүртэл хувиар бууруулах зорилтыг тусгасны хүрээнд 2020 онд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг Налайх дүүрэгт байгуулсан. Тус үйлдвэр нь жилд 600,000 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус үйлдвэр нийт 1100 ажилтан ажиллах орон тоотойгоос одоогоор 760 ажилтан ажиллаж байна. Үүний 520 ажилтан нь Налайх дүүргийн иргэд бөгөөд 350 гаруй ажилтан нь хаагдсан уурхайд ажиллаж байсан хүмүүс байна. Өөрөөр хэлбэл уурхай хаагдсаны дараа уурхайд ажиллаж байсан хүмүүсийн шилжиж ажиллах гол ажлын байрны нэг нь тус үйлдвэр болсон.

Зураг 5 Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр



Эх сурвалж: Зохиогчийн зураг

2.3.2.3 Хог боловсруулах үйлдвэр

Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хог боловсруулах үйлдвэрүүд нь хаягдал төмөр, хөнгөн цагаан хайлш, гялгар уут, хуванцар сав, дугуй, үртэс, шил дахин боловсруулж байна.

2.4 Эрчим хүч, түлш

2.4.1 Эрчим хүч

Дүүргийн суурилагдсан хүчин чадал 129,2МВт байдаг бөгөөд өмнөх оны мөн үеэс 4,3 хувь нэмэгдсэн. 16 дэд станцад 5,3МВт чадал нэмэгдсэн. Мөн гэр хорооллыг тэжээж байгаа дэд станцад 10МВт ачаалал нэмэгдснээр 6 дэд станцийн ачаалал огцом нэмэгдсэн. Эдгээр хэсгүүдэд сип кабелийг давхарлах, ачаалал тэнцүүлэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар 1,7 дугаар хороонд цахилгаан хангамжийн ачаалал их байна.

Дүүргийн цахилгаан хангамжийн хэрэглээ жил бүр 5 хувиар өсөж байна. Дүүргийн 8 хорооны 802 аж ахуйн нэгж, гэр хорооллын-7600 өрх, орон сууцны- 2894 айл, өрх төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдсон байдаг.

2.4.1.1 Орон сууцны салбар

Налайх дүүрэгт нийт 113 орон сууцны барилга байна. Төвийн хэсэгт 101 барилга, 12 барилга нь 5-р хороонд байна. Үүний 38 нь угсармал барилга байна.

Налайх дүүргийн 2-р хороонд 1977-2008 онд баригдсан 28 ширхэг 878 айлын угсармал орон сууцны барилга байдаг. Уг угсармал барилгууд нь 4.8 Гкал/цаг дулааны ачаалалтай байгаа бөгөөд 30-35% нь дулаан алдагдалтай байсан. Нийт угсармал барилгын 31 орон сууцны барилгад дулаан техникийн шинэчлэлийн (гадна фасадны дулаалга) ажлыг хийсэн. 5-р хороонд 1969-1972 онд баригдсан 420 айлын 7 угсармал орон сууц нь нийт 1.7 Гкал/цаг дулааны ачаалалтай байгаа бөгөөд дулаан техникийн шинэчлэлийн ажлыг хийх шаардлагатай байгаа.

1956-1976 оны хооронд баригдсан нийт 33 ширхэг 2 давхар тоосгон хуучин орон сууцны барилгуудын эдэлгээний хугацаа дууссан. Тус барилгуудыг буулган дахин барилгажуулах шаардлагатай бөгөөд эхний ээлжийн 280 айлын барилгажилтын төсөлд 5,89Гкал/цаг-ийн дулааны эрчим хүчний хэрэглээ шаардлагатай байна.

Орон сууцны барилгуудын жилийн нийт дулааны хэрэгцээ 19.4 Гкал/цаг, цахилгааны хэрэгцээ 6.3 сая кВт.ц байн.

2.4.1.2 Аж ахуйн нэгж ба үйлдвэрлэлийн салбар

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний судалгаагаар 2020 онд Налайх дүүрэгт 5,856 ажлын байр, 1658,314 м² талбай бүхий ажлын байрны барилга байсан байна. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн барилгуудын жилийн нийт дулааны хэрэгцээ 23.5 Гкал/цаг, цахилгааны хэрэгцээ 160.3сая кВт.ц байна.

2.4.2 Түлш

Налайх Дулааны станц нь жилд 37,000 тн нүүрс, 113,000 м³ ус, 3,783,000 кВт цахилгаан эрчим хүч, 25,000 л шатахуун зарцуулдаг байна. Зуух ашиглан халаалтаа шийдэж буй гэр хорооллын айл өрхүүд нийтдээ жилд 12,500 тн түлшийг хэрэглэж байна.

2.4.3 Сэргээгдэх эрчим хүч

Дүүргийн гуравдугаар хороонд 2019-2020 онд БНСУ-ын дэмжлэгээр 400кВа 80 айл өрхийг хангах чадалтай 6 салхин сэнс 21 сектор нарны панелиг угсарсан хэдий ч одоогоор ашиглалтад ороогүй байна.

Зураг 6 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр



Эх сурвалж: Зохиогчийн зураг

2.5 Тулгамдаж буй асуудал

Налайх дүүргийн одоогийн байдлын судалгаа болон холбогдох байгууллагуудтай хийсэн уулзалтууд, фокус группын ярилцлагууд, иргэдээс судалгаануудын үр дүнд үндэслэн ЖЕТ-тэй холбоотой дараах үндсэн салбаруудад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлов.

2.5.1 Нийгэм, эдийн засгийн тулгамдаж буй асуудал

- **Эдийн засгийн нэг салбараас хамааралтай байдал:** Налайх дүүргийн эдийн засаг уул уурхай, үйлдвэрийн салбараас ихээхэн хамааралтай бөгөөд бусад салбарууд төдийлөн сайн хөгжөөгүй. Иймээс эдийн засаг нь бусад дүүргүүдтэй харьцуулахад сул бөгөөд төрийн бодлого, цар тахал, дэд бүтцийн хангамж зэргээс нийгэм, эдийн засаг, байгалийн өөрчлөлтөд амархан өртдөг байх магадлалтай.
- **Төсвийн алдагдал, татаас:** Налайх дүүргийн төсвийн зарлага нь орлогоос хэтэрч, орлогоор зарлагаа санхүүжүүлж чаддаггүй учир улс, нийслэлийн татаасаар үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтаа санхүүжүүлдэг.
- **Ажиллах хүчний огцом бууралт:** Налайх дүүргийн эдийн засгийн хөдөлгүүр нь нүүрсний уурхай байсан. Гэвч эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, урьдчилан бэлтгэл арга хэмжээ хангалттай хийгээгүйгээс уурхайн ажилчид ажилгүй болсон. Улмаар 2017 онтой харьцуулахад ажиллах хүчний тоо огцом 2,534 хүнээр буюу 18%-иар буурчээ. Ажилгүй болсон уурхайн ажилчдад тохирсон ажлын байр хангалтгүй байна.
- **Жендэрийн тэгш бус байдал:** Эмэгтэйчүүдийн ялангуяа 15-39 насны залуу эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдтэй харьцуулахад бараг 2 дахин бага байна.
- **Ажилгүйдэл, ядуурал:** 2017 онд эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төвөөс нийслэлийн дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааг хийсэн. Уг судалгаагаар Налайх дүүрэг нийслэлийн хамгийн өрсөлдөх чадвар багатай дүүрэг байсан.
- **Цэцэрлэг, сургуулийн боловсон хүчний дутагдал:** Налайх дүүрэгт 1 цэцэрлэгийн үндсэн багшид 31 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшид 22 сурагч ногдож байна. Энэ нь нийслэлийн үзүүлэлттэй харьцуулахад их байна

2.5.2 Дэд бүтцийн тулгамдаж буй асуудал

- **Дулааны эх үүсвэрийн асуудал:** Дулаан хангамжийн эх үүсвэр болох Налайхын дулааны станцын тоног төхөөрөмж хуучирч зуухны ашигт үйлийн коэффициент (66%) буурсан, шугам сүлжээ нь элэгдэж хуучирсан байна. Дулааны шугам сүлжээний 40%-ийг шинэчлэх шаардлагатай болсон. Түүнээс гадна хэрэглэгчдийн дулааны ачаалал нь станцын бодит хүчин чадлаас хэтэрсэн учир шинээр бүтээн

байгуулалт хийхэд хангалтгүй болж байна. Тиймээс одоогийн байдлаар төрийн үйлчилгээний барилга байгууламжаас бусад барилгад техникийн нөхцөл олгохгүй байгаа.

- **Дулаан, цахилгааны эрчим хүчний өсөн нэмэгдэх эрэлт:** Налайх дүүрэгт сүүлийн 10 жилд өрх 1.2 дахин, ААНБ 2.4 дахин нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор цаашид дулаан, цахилгааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ үүсэж байна.
- **Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамж:** Төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбогдоогүй 7,600 гэр хорооллын айл өрх зууханд нүүрс түлж халаалтаа шийдэж байна. Түүнээс үүдэн жил бүр 12,500 тн сайжруулсан түлшийг халаалтад ашиглаж байна. Гэвч дулаан хангамжийг өөр шийдлээр солиход иргэдийн мэдлэг, мэдээлэл, айл өрхийн санхүүгийн байдал, орлуулан ашиглах тоног төхөөрөмж, түлшний хангамж хязгаарлагдмал байна.

2.5.3 Уул уурхай, үйлдвэрийн тулгамдаж буй асуудал

- **Байгаль орчны бохирдол:** Бичил уурхайн улмаас 338 га талбай эвдрэлд орж, байгаль орчныг бохирдуулсан. Үүнийг нөхөн сэргээхэд ихээхэн хэмжээний санхүүжилт шаардлагатай байна.
- **Үйлдвэрүүдийн хэмжээ, ажлын байр:** Налайх дүүрэгт одоо үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн дийлэнх нь 1-9 хүнтэй маш жижиг хэмжээний үйлдвэрүүд байна.

2.5.4 Эрчим хүчний тулгамдаж буй асуудал

- **Угсармал барилгын дулаан алдагдал:** Налайх дүүрэгт дулаан техникийн шинэчлэл хийгдээгүй 420 айлын 7 угсармал барилгууд байна. Тус барилгууд 50 болон түүнээс жилийн насжилттай бөгөөд дулаан алдагдал нь 30-35% байна.
- **Гэр хорооллын айл өрхийн сууцны дулаан алдагдал:** Гэр хорооллын ихэнх айл өрхүүд сууцаа дулаан алдагдалтай байгааг мэддэг ч арга хэмжээ авдаггүй. Энэ нь иргэдийн мэдлэг, мэдээлэл дутуу байх эсвэл санхүүгийн бололцоогүй байх зэрэг янз бүрийн шалтгаантай байна. Тиймээс цаашид иргэдэд дулаан алдагдлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх, сууцны дулаан алдагдлаа бууруулахад нь дэмжлэг үзүүлэх шаардлага үүсэж байна.
- **Дулааны станцын түлшний хэрэглээ:** Дулааны станц нь жилд 37,000 тн нүүрс зарцуулж байна. Цаашид дулаан, цахилгааны ачааллыг нэмэгдүүлэхийн тулд өргөтгөл, шинэчлэл хийх шаардлагатай бөгөөд хэрэв уламжлалт дулаан, цахилгаан станц баригдвал нүүрсний хэрэглээ улам нэмэгдэнэ.
- **Дулааны станц агаарын бохирдлын эх үүсвэр:** Одоогийн байдлаар дулааны станц нь агаарын бохирдлын 20 орчим хувийг ялгаруулж байна.

- **Сэргээгдэх эрчим хүчний ашиглалт, менежмент:** Дулаан, цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээг нэмэхгүй байхын тулд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг шинээр бий болгож, станцын үйл ажиллагааг тогтвортой, тасалдахгүй, үр ашигтай явуулах шаардлагатай. Налайх дүүрэгт нарны станц шинээр байгуулсан хэдий ч ажиллагаагүй байна. Үүнээс үзэхэд цаашид сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр ажиллах хүчийг бэлтгэх зайлшгүй шаардлага үүсэж байна.
- **Эрчим хүчний үр ашиггүй зарцуулалт, үргүй зардал:** Эрчим хүчний шилжилт хийхэд эрчим хүчийг хэмнэх нь эн тэргүүний асуудал боловч эрчим хүчний үр ашиггүй зарцуулалт, зардал гарч байна. Жишээлбэл, Налайх дүүрэг дулааны улиралд айл өрхүүдийг дулааны станцын халуун усаар хангадаг нь их хэмжээний эрчим хүч, зардлыг үр ашиггүй зарцуулж байдаг. Тиймээс дулааны улиралд айл өрхүүдийн халуун усыг сэргээгдэх эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах асуудал үүсэж байна.
- **Түлшний чанарын асуудал:** Түүхий нүүрсний хэрэглээг хорьж, бохирдол багатай, илчлэг ихтэй сайжруулсан түлшийг ашиглаж эхэлсэн. Гэвч сайжруулсан түлш нь түүхий нүүрстэй харьцуулахад илүү чанаргүй, бохирдол ихтэй байна гэсэн иргэдийн гомдол их байна

2.6 SWOT анализ

JET стратеги боловсруулахад Налайх дүүргийн одоогийн нөхцөл байдлын SWOT анализыг одоогийн байдлын судалгаа, оролцогч талуудын уулзалт, судалгаанд үндэслэн боловсруулав.

Хүснэгт 1 SWOT анализ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Нүүрсний уурхайн үйл ажиллагааг бүрэн зогсоосон. Уурхайн газрын нөхөн сэргээлтийг үе шаттайгаар зохион байгуулж байгаа.	Дүүрэг санхүүгийн хувьд нийслэлээс шууд хамааралтай, татаас авдаг, бие даан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүгийн боломжгүй.
Барилгын материал үйлдвэрлэл технологийн парк, Таван толгой түлш ХК зүүн бүсийн үйлдвэрийн ажлууд явагдаж шинээр ажлын байруудыг бий болгож байна. Уурхайн ажилчид шилжин ажиллаж эхэлсэн.	Уурхайд ажиллаж байсан иргэдийг ажлын байраар бүрэн хангаж чадаагүй, ажилгүйдлийн түвшин өндөр.
Политехникийн коллеж, Монгол Германы хамтрсан ашигт малтмал технологийн их сургуулиуд нээгдэж мэргэжилтэй ажилтан бэлтгэх боломж нээгдсэн.	Дүүрэг шинээр эрчим хүчний хэрэглээг хангах боломжгүй байгаа.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Төсвийн цэцэрлэг, сургуулиуд нүүрснээс татгалзаж, хийн түлшээр халаадаг бие даасан дулааны эх үүсвэртэй болсон.	Цахилгааны чадал муу, зардал өндөр, зарим хэсгээр эрчим хүчний уналттай байна.
Угсармал орон сууцны барилгуудын ихэнхт дулаан техникийн шинэчлэлийн ажил хийгдсэн.	Гэр хорооллын иргэд сайжруулсан түлшнээс илүү түүхий түлшээ хэрэглэх сонирхолтой болсон.
Гэр хорооллыг дэд бүтцэд холбох ажлыг эхлүүлсэн.	Нүүрс хэрэглээний үр дагавар, түүнээс татгалзах талаар ойлголт муу, сургалт сурталчилгаа дутмаг.
Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх нөөц талбайтай, эхний санаачлага хийгдсэн.	Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний талаар мэдлэг тааруу, санхүүгийн бэрхшээлтэй.
185 МВт-ын дулаан станцын зураг төслийн ажил хийгдсэн.	Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх ажил удаашралтай, төлбөрийн чадвар муу.
	Айл өрхүүдэд дулааны тоолуур суурилуулаагүй тул дулааны эрчим хүчний хэмнэлтийг хэмжих, тохируулах боломжгүй.
	Цахилгаан автомашины цэнэглэх станц байхгүй.
БОЛОМЖ	АЮУЛ
Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, ложистикийг хөгжүүлж эдийн засгаа төрөлжүүлэх, шинэ ажлын байр, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой. Тодорхой ажлууд хийгдээд явж байгаа.	Цахилгаан хангамжийг сайжруулах чиглэлийн улсын ажил удааширвал цахилгаан хангамжийн хомсдол үүсэх.
Уурхайн газрыг нөхөн сэргээж ногоон байгууламж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих, аялал жуулчлалыг (музей барих) хөгжүүлэх боломжтой.	Дулааны шинэ станц байгуулах ажил удаашрах, зогсох.
Барилгын материал, үйлдвэр, технологийн паркийн хүрээнд цахилгаан эрчим хүчний эх үүсвэр, ажлын байр нэмэгдэх боломжтой.	Хүн ам нэмэгдэж эрчим хүчний хэрэглээ огцом өсөх.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Нар болон салхин сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх боломжтой, нөөц талбайтай.	Дүүргийн удирдлагууд өөрчлөгдөх, СЭХ-ийг дэмжих ажил удаашрах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удаашрах.
Таван толгой түлшний үйлдвэрээс хямд, үр ашиг өндөртэй шинэ төрлийн түлш үйлдвэрлэн ашиглах.	Зарим гэр хорооллын иргэд дулааны асуудлаа цахилгаанаар шийдэж буй хэдий ч зардал өндөр. Хэрэв улсаас дулаан, цахилгааны төлбөрийг нэмвэл иргэд нүүрс ашиглах өндөр магадлалтай.
Эрчим хүчний зохистой шилжилт хийхэд дүүргийн удирдлагууд дэмжиж байгаа.	
Эрчим хүчний зохистой шилжилтийг хийхэд олон талын хамтын ажиллагааг бэхжүүлэх.	
Гэр хорооллын айл өрхийн сууц, төрийн байгууллагуудыг барилгуудыг дулаалах, эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх.	

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

III. Үйл ажиллагаа 2. Хууль, бодлогын баримт бичгийн шинжилгээ

Хууль эрх зүйн орчин болон бодлогын баримт бичгийн судалгааны хүрээнд JET-ийн хүрээний салбаруудад мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичиг болон улс, салбар, нийслэл, дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүдийг судалж үнэлэлт, дүгнэлт гаргав. Үүнд:

Налайх дүүргийн хэмжээнд зохистой эрчим хүчний шилжилтийг хийхэд хууль эрх зүйн хүрээнд заасан одоогийн чиг үүрэг, зохицуулалтыг тодорхойлох. Бодлогын баримт бичгийн судалгааг үндсэн 4 түвшинд буюу улсын, эдийн засгийн салбаруудын, Улаанбаатар хотын болон орон нутгийн буюу Налайх дүүргийн хэмжээнд батлагдсан зохистой эрчим хүчний шилжилттэй холбоотой голлох нийгэм, эдийн засаг, эрчим хүч, уул уурхай, хөдөлмөр эрхлэлт, хот төлөвлөлт, дэд бүтцийн салбарын бодлогуудыг судлан дүгнэв.

Налайх дүүрэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн, түүнээс алслагдсан дүүргийн нэг юм.

3.1 Хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа

үүргийн эрх зүй, эрчим хүч, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын баримт бичигтэй холбоотой 7 хууль эрх зүйн баримт бичигт судалгаа хийлээ.

Хүснэгт 2 Холбогдох хууль эрх зүйн баримт бичигт JET-ийн салбаруудын талаар тусгагдсан байдал

Хууль бодлогын баримт бичиг	JET хамрах хүрээ					
	Стратеги	Засаглал	Эрчим хүч	Үйлдвэр-лэл	Уул уурхай	Ажил эрхлэл
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль						
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль						
Эрчим хүчний тухай хууль						
Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль						
Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль						
Төсвийн тухай хууль						

Түүхий тээвэрлэхийг шийдвэр	нүүрс	хэрэглэх, хориглосон					
-----------------------------	-------	----------------------	--	--	--	--	--

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар дүүргийн эрх зүйн байдал, чиг үүрэг, төсөв, сангийн зохицуулалтуудыг тусгасан. Уг хуульд зохицуулснаар дүүрэг нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, дүүргийн өмчийн захиран зарцуулалт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хариуцна. Мөн төсвийн бус хөрөнгөөр Төсвийн тухай хуульд зааснаас бусад сантай байж болохоор заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо ба түүнд оролцогч талуудын эрх, үүрэг, баримт бичиг боловсруулах үе шат, санхүүжилтийн эх үүсвэр зэргийг зохицуулсан. Тус хуульд тусгаснаар дүүргийн Засаг дарга улсын урт, дунд хугацааны бодлого, нийслэлийн дунд хугацааны бодлогуудтай уялдуулан дүүргийн Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь тухайн орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх шаардлагатай.

Эрчим хүчний тухай хуульд дүүргийн Засаг даргын бүрэн эрх, эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүч түгээх, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл, эрчим хүчний үнэ тариф ба түүнийг тогтоох зарчим зэргийг зохицуулсан. Уг хуульд зааснаар дүүргийн Засаг дарга дүүргийн эрчим хүчний хангамжийн талаархи бодлого боловсруулж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд дүүргийн Засаг даргын бүрэн эрх, эрчим хүч хэрэглэгчийн эрх, үүргийг зохицуулсан байна. Тус хуульд зааснаар дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. Эрчим хүчний хэмнэлтийн хуулиар эрчим хүчний үүрэг хүлээсэн томоохон хэрэглэгчийг тодорхойлж, тус ангилалд багтахад баримтлах босго түшинг тогтоосон байна. Түүнчлэн эрчим хүчний томоохон хэрэглэгчид жил бүр өөрсдийн эрчим хүчний хэрэглээ болон түүнийг багасгахад авч хэрэгжүүлж буй төлөвлөлтөө танилцуулсан тайлан гаргаж өгөх үүрэгтэй байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд дүүргийн Засаг даргын бүрэн эрх, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг зохицуулсан. Уг хуульд тусгаснаар дүүргийн Засаг дарга дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах газрыг тусгах, газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг

шийдвэрлэх, орон нутгийн өмчийн сэргээгдэх эрчим хүчний үүсвэрийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх, сэргээгдэх эрчим хүчний талаар иргэд, олон нийтэд сурталчилгаа хийх зэрэг үүрэгтэй байна.

Төсвийн тухай хуульд зааснаар дүүргийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба түүнд ажлаа тайлагнадаг байгууллагуудын төсвөөс бусад орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч байна. Дүүргийн төсвийн орлого нь хувь хүний орлогын албан татвар, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр зэргээс бүрдэнэ. Татварын бус орлого нь орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааны ногдол ашиг, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого, хууль тогтоомжийн дагуух бусад орлогоос бүрдэнэ. Дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болно. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Налайх дулааны станцаас бусад дулаан, эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Харин байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэн дулаан, уур үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж, байгууллагад сайжруулсан шахмал түлш, мидлинг хэрэглэхийг зөвшөөрсөн.

3.2 Бодлогын баримт бичгийн судалгаа

Бодлогын баримт бичгийн судалгаагаар үндэсний хэмжээний 4, салбарын 1, нийслэлийн 6, дүүргийн 4 баримт бичгийг судаллаа.

Хүснэгт 3 Бодлогын баримт бичигт JET-ийн салбаруудын талаар тусгагдсан байдал

Түвшин	Хууль бодлогын баримт бичиг	Стратеги	Засаглал	Эрчим	Үйлдвэр-/улуурхайжилэрхлэл	Урлаг	Тусгай
Улс	Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт (NDC)						
	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого						
	Шинэ сэргэлтийн бодлого						
	Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл						
Салбар	Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах 2020-2030 оны төлөвлөгөө						
Нийслэл	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө						
	Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл						
	Улаанбаатар хотын Эрчим хүчний мастер төлөвлөгөө						
	Орон нутгийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө						
	Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө						
	Улаанбаатар хотыг Ногоон хот болгох үйл ажиллагааны төлөвлөгөө						
Дүүрэг	Налайх дүүргийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө						
	Налайх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр						
	Налайх дүүргийн Тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг						

Налайх дүүргийн дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын сүлжээний мастер төлөвлөгөө

--	--	--	--	--	--

Тайлбар: Дээрх баримт бичгүүдэд улс/нийслэл эсвэл дүүргийн түвшинд бодлого, арга хэмжээ тусгасан эсэхийг дараах байдлаар тэмдэглэв. Үүнд:


■ Улс, нийслэл ■ Налайх дүүрэг

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

3.2.1 Үндэсний бодлогын баримт бичгийн судалгаа

Энэ судалгааны хүрээнд үндэсний хэмжээний дараах бодлогын баримт бичгүүдийг судаллаа.

Зураг 7 Бодлогын баримт бичиг



Эх сурвалж: Зохиогчийн зураг

Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт (NDC)-д хүлэмжийн хийн ялгарлыг нэгдсэн зорилтын хүрээнд хууль эрх зүй, бодлого, төлөвлөлтийн орчин бүрдүүлэх, санхүүжилтийн механизмыг бий болгох, байгальд ээлтэй дэвшилтэт, өндөр бүтээмжтэй технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголт, мэдээллийг түгээж бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах үндэсний, салбарын, орон нутгийн бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах арга хэжээг тодорхойлжээ. Уг баримт бичигт Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг эрчим хүч, аж үйлдвэр, зам тээвэр, барилгын салбарт нийтдээ 11.5 сая тонноор бууруулах тодорхойлжээ. Эрчим хүч үйлдвэрлэл, хангамжийн салбарт 8.34 сая тонн CO₂-ыг сэргээгдэх эрчим хүч ашиглалт, эрчим хүчний хангамжийн үр ашгийг дээшлүүлэх замаар бууруулна. Аж үйлдвэрийн салбарт 1.2 сая тонн CO₂-ыг аж үйлдвэрийн эрчим хүчний хэмнэлт, цементийн үйлдвэрийн хаягдал дулаанаар цахилгаан үйлдвэрлэх, нүүрсний уурхайн метаныг ялган авч цахилгаан үйлдвэрлэх замаар бууруулна. Зам тээврийн салбарт 1.05 сая тонн CO₂-ыг Евро 4, 5 стандартын шатахуунд шилжсэнээр бууруулна. Барилгын салбарт 0.83 сая тонн CO₂-ыг сайжруулсан түлш хэрэглэх, угсармал орон сууцыг дулаалах замаар бууруулна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогоор Монгол Улсыг 30 жилийн хугацаанд хөгжүүлэх үндсэн 9 зорилгыг боловсруулсан байдаг. Хүний хөгжлийг сайжруулах зорилгын хүрээнд иргэн бүрийг ажилтай орлоготой болгох; Амьдралын чанар ба дундаж давхаргыг дээшлүүлэх зорилгын хүрээнд айл өрхүүдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах, жижиг, дунд бизнес эрхлэлтийг дэмжих, дундаж давхаргыг санхүүгээр дэмжих; Эдийн засгийг хөгжүүлэх зорилгын хүрээнд эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн систем хөгжүүлэх; Засаглалыг сайжруулах зорилгын хүрээнд төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд оролцогч талуудын оролцоог хангах; Ногоон хөгжлийн зорилгын хүрээнд Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах; Бүс, орон нутгийг хөгжүүлэх хүрээнд бүс нутгуудыг дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр холбох; Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх зорилгын хүрээнд хотын сайн засаглалыг бий болгох, дагуул хотуудыг хөгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгажээ.

Мөн уг баримт бичигт алслагдсан дүүргүүдийн хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлсон. Жишээлбэл дагуул хотууд руу дагуул хотуудад ажлын байрыг бий болгох замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, их дээд сургуулиудыг дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлэх, Улаанбаатар дахь үйлдвэрүүдийг дагуул хотууд руу шилжүүлж кластер үүсгэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий дулааны эх

үүсвэрүүдийг барих, үйлдвэр технологийн паркуудыг барих зэрэг үйл ажиллагааг төлөвлөжээ.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээд эрчим хүчний сэргэлтийн бодлогыг боловсруулсан. Энэ хүрээнд эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээг шинээр барьж байгуулах, усан болон хуримтлуурын цахилгаан станц барьж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэж тусгагджээ.

Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баримт бичигт нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийг бий болгох зорилгын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг 12.3%-иар бууруулахаар тусгажээ.

3.2.2 Салбарын бодлогын баримт бичгийн судалгаа

Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах 2020-2030 оны төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлтөд барилга, хот байгуулалтын салбарын сөрөг нөлөөллийг бууруулж, хүлэмжийн хийг багасгах 5 зорилт тавьсан. Тус төлөвлөгөөний Зорилт 1 буюу хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд одоо байгаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах мөн шинээр ногоон барилгын санхүүгийн хөшүүрэг, ногоон хот, суурин, барилга байгууламжийн үнэлгээний эрх зүйн орчин бүрдүүлэх, ногоон, тогтвортой хот, суурин, барилга байгууламжийн норм дүрэм, журмыг боловсруулах, дулааны цахилгаан станцуудын хаягдал үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд хэрэглэх боломжийг судлах, иргэдэд дулаан алдагдал, эрчим хүчний хэмнэлттэй барилгын талаар сурталчилж ногоон барилгын эрэлтийг нэмэгдүүлэх зэрэг ажил тусгагджээ. Зорилт 2 буюу эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд барилгын материалын үйлдвэрүүдийн нүүрс, ус, цахилгаан, дулааны жилийн хэрэглээний талаар мэдээллийн сан үүсгэх, гэр хороололд нөөцийн хэмнэлттэй дэд бүтцийг байгуулах, нам даралтын зуухтай барилгуудын дулааныг нүүрс болон сэргээгдэх эрчим хүч хосолсон технологиор шинэчлэх, эрчим хүчний аудитын дүгнэлтээр D, E ангилалд багтсан барилгуудыг дулаалах ажлуудыг хэрэгжүүлнэ. Зорилт 3 буюу уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хот төлөвлөлтийг хөгжүүлэх зорилтын хүрээнд ногоон хот, суурины үнэлгээний аргачлалын дагуу хот, суурин газрыг үнэлэх, хот суурин газарт уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийж дасан зохицох төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, хэрэглэгчийн ус, дулааны шугам сүлжээнд ухаалаг тоолуур суурилуулж барилгуудын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжиж, тайлагнах, нотлох мэдээллийн сан бүрдүүлэх, барилга байгууламжид эрчим хүчний аудит хийж, гэрчилгээжүүлэх, угсармал орон сууцыг дулаалах ажлуудыг хэрэгжүүлнэ. Зорилт 4 буюу ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ногоон барилга, барилгын материалыг дэмжих санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлнэ. Зорилт 5 буюу барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, нотлох системийг

бүрдүүлэх зорилтын хүрээнд энэ чиглэлээр ажиллах төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хүлэмжийн хийн тооллогын цахим системд холбогдоогүй бие даасан дулаан хангамжийн эх үүсвэртэй гэр, орон сууц, олон нийт, иргэний барилгыг бүртгэх, сайн дураар хүлэмжийн хийн ялгарлыг тайлагнах тогтолцоог бүрдүүлж, иргэдэд сурталчлах ажлуудыг төлөвлөжээ.

3.2.3 Нийслэлийн бодлогын баримт бичгийн судалгаа

Нийслэлийн түвшинд дараах бодлогын баримт бичгүүдийг судаллаа.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хотын одоогийн байдлын иж бүрэн судалгааг хийж тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон бөгөөд хотын хөгжлийн стратеги, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагуудыг тодорхойлсон байна. Тус баримт бичигт Улаанбаатар хотын хөгжлийн 6 үндсэн стратегийг тодорхойлсон. Засаглалыг сайжруулах хүрээнд сайн засаглал, хууль эрх зүйн тогтвортой орчин бүрдүүлэх, хаяа, дагуул хот тосгодын хөгжлийг бодлогоор дэмжих; Эдийн засаг, үйлдвэрлэлийг сайжруулах хүрээнд олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх, дэд бүтцийн хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх; Түлш, эрчим хүчний чиглэлд байгаль орчны бохирдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах; Уул уурхайн салбарт байгалийн шавхагдах нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд ядуурлын түвшинг бууруулах, хүн амын мэдлэгийн чанар, хэрэглээг дэмжин хөгжүүлэх зэрэг стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлжээ.

Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь “Алсын хараа-2050” баримт бичигт тодорхойлсон үндсэн 9 зорилгыг нийслэлийн түвшинд хэрэгжүүлэхээр боловсруулсан баримт бичиг юм. Уг баримт бичигт нийслэлийг олон тулгуурт, бие даасан эдийн засагтай болгох, үүний хүрээнд инновацыг хөгжүүлэх, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, бүтээлч эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлжээ. Засаглалыг сайжруулах хүрээнд нийслэл дэх захиргааны төвлөрлийг сааруулах, нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн сан, сүлжээнд холбох зорилтыг тавьжээ. Ногоон хөгжлийг бий болгох зорилгын хүрээнд гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна. Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх зорилгын хүрээнд угсармал орон сууцны барилгыг дулаалах, ашиглалтын хугацаа дууссан шугамуудыг шинэчлэх, технологийн шинэчлэл хийж хүн амыг тогтвортой цахилгаанаар хангах, дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох зэрэг зорилтуудыг тавьжээ.

Улаанбаатар хотын Эрчим хүчний мастер төлөвлөгөөнд Улаанбаатар хотын эрчим хүч, дулааны 2050 оны эрэлтийн хэтийн төлөвийг салбаруудаар тооцоолсон байдаг. 2016 оны суурь түвшинтэй харьцуулахад Улаанбаатар хотын эрчим хүчний эрэлт 2050 он гэхэд суурьшлын бүсэд 100% (1,564 ГВтц/ж), аж ахуйн нэгж, үйлдвэрийн салбарт 37% (1,618 ГВтц/ж) өснө гэж тооцоолжээ. Харин дулааны эрчим хүч 2050 онд нийт 36%-иар өсөж 13,824 ГВтц/ж болох бөгөөд үүний 69%-ийг орон сууц, 6%-ийг гэр сууц, 25%-ийг аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн салбарын дулаан хангамжид ашиглана гэж тооцоолсон байна. Тээврийн салбарын хувьд 2050 онд нийт зорчигч тээврийн 30%, ачаа тээврийн 10%-ийг цахилгаан тээврийн хэрэгсэл эзлэх бөгөөд үүнд нийтдээ 161 ГВтц/ж дулаан ашиглана гэж тооцсон. Харин цахилгаан бус тээврийн хэрэгсэлд ний 2,748 ГВтц/ж түлш шаардлагатай бөгөөд энэ нь 810 ктнCO₂eq/жил хүлэмжийн хий ялгаруулна гэж үзжээ. Түүнчлэн тус баримт бичигт нийт эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээнд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийн эзлэх хувь 2030 онд 74%, 2050 онд 77%-д хүрнэ гэж төлөвлөжээ.

Орон нутгийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь Улаанбаатар хотын барилгын шинэчлэл, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, түүнд шаардлагатай менежментийн бүтэц, үйл явцыг тодорхойлсон. Орон нутгийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд 15 үндсэн үйл ажиллагааг олон нийтийн барилга, гэр хороолол дахь нэг айлын сууц, олон айлын барилга, шинэ барилга гэсэн ангиллаар тодорхойлжээ.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах 2018-2025 оны мастер төлөвлөгөөнд 2020-2025 онд хэрэгжүүлэх 5 зорилтыг дэвшүүлсэн байна. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд дагуул хотуудад нийгэм, эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх замаар иргэдийг татах, ажлын байраар хангах, хотын ойр орчимд элс, хайрганы олборлолт, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг хязгаарлаж газрыг нөхөн сэргээх ажлуудыг хийхээр төлөвлөжээ. Түүхий нүүрсний хэрэглээг хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах зорилтын хүрээнд дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг хориглох, түлш, гэрийн зуухтай холбоотой стандартуудыг иргэдэд сурталчлах, ногоон зээлийн сан байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улаанбаатар хотыг Ногоон хот болгох үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр эрчим хүчний, тээврийн системийг өөрчлөх замаар агаарын чанарыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, байгальд ээлтэй шийдлээр цаг уурын хүндрэлийг даван туулах, ногоон орчин бүрдүүлэх, иргэдийн оролцоог сайжруулах замаар аз жаргалтай хот бий болгох гэсэн 4 үндсэн стратегийн зорилго тавьжээ. Энэ стратегийн хүрээнд гэр хороололд дэд бүтэц, орлогод нийцсэн ногоон орон сууцыг хөгжүүлэх, төвлөрсөн халаалтын шинэчлэл хийх, салбар дундын ногоон эрчим хүчний шийдэл хэрэгжүүлэх, барилгын эрчим хүчний хэмнэлт гаргах зэрэг 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ.

3.2.4 Дүүргийн бодлогын баримт бичгийн судалгаа

Налайх дүүргийн хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдийг судаллаа.

Налайх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг улс, нийслэлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан. Энэ баримт бичигт засаглалыг сайжруулах хүрээнд дүүргийн Засаг Даргын Тамгын Газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод болгоно. Эрчим хүчний чиглэлээр гэр хорооллын айл өрхөд шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлэх, халаалтыг шөнийн дулаан хуримтлуур, цахилгаан халаагуураар шийдсэн өрхийн тоог нэмэгдүүлэх, сууцны дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөжээ. Мөн цахилгаан, дулааны эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэх, өргөтгөх, шинэчлэх, төрийн өмчийн халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох, төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломжгүй аж ахуйн нэгжүүдийн халаалтын зуухыг хийн түлшинд шилжүүлэх зэрэг арга хэмжээ авахаар тусгажээ. Эдийн засаг, аж үйлдвэрийн чиглэлд нийслэлээс авах санхүүгийн дэмжлэгийг бууруулах, барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк болон инновацын төвийг барьж байгуулах, эрчимжсэн мал аж ахуйг кластер байдлаар хөгжүүлэхээр төлөвлөжээ. Уул уурхайн чиглэлээр уул уурхайн улмаас эвдэрч доройтсон газруудыг нөхөн сэргээх, нөхөн сэргээлт хийгдсэн газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч ногоон бүс болгох, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтод хяналт тавьж, нөхөөн сэргээлт хийлгэх ажлуудыг төлөвлөсөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гарааны бизнесүүдийг дэмжих дундын оффис, инкубатор төвүүдийг байгуулах, үндэсний хэмжээний уул уурхай, барилга, бүтээн байгуулалтын төслүүдэд иргэдийг зуучилж хамруулах, дүүргийн хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан боловсон хүчнийг төрөлжүүлэн бэлтгэх зэрэг ажлуудыг тусгажээ.

Налайх дүүргийн 2015-2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дүүргийн хөгжлийн үндсэн стратеги, хүн ам, нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн хангамж, орон сууц хэтийн төлөв, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалт, удирдлага зохион байгуулалт болон хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна. Уг баримт бичигт дүүргийн хөгжлийн үндсэн стратегийг тодорхойлохдоо өрхийн аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик, барилгын материал үйлдвэрлэл, утаагүй түлшний үйлдвэрлэл, мэргэжил сургалт үйлдвэрлэл хөгжсөн үйлдвэрлэл, үйлчилгээнд суурилсан эдийн засагтай болгох, Улаанбаатар хотын зарим үүргийг шилжүүлэх замаар хотын хүн амын ачааллыг багасгах, одоогийн гэр хорооллын нөхцөлийг сайжруулах замаар амины сууцны хороолол бий болгох, үйлдвэрийн бүсийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулна гэж тусгажээ. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Налайх дүүрэг 2030 он гэхэд 54,000 хүн, 22,000 өрх, 30,000 ажиллагч, 17,000 айлын орон сууцтай байна гэж тооцоолсон. Мөн Налайх дүүрэг 2030 он гэхэд жилд 0.85 сая тонн нүүрсний хэрэгцээтэй болно гэсэн тооцоолол хийжээ.

Налайх дүүргийн Тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг амьдрахад таатай, дэд бүтцийн хөгжил сайтай орчин бүрдүүлж, байгаль ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлж, аялал жуулчлалын төв, ногоон хөгжлийн жишиг болгох зорилгоор дунд хугацаанд буюу 2020-2028 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Уг баримт бичигт дүүргийн хүн ам 2030 он гэхэд 47,700 болно гэж тооцоолсон бөгөөд бодлогыг хэрэгжүүлснээр зохистой ажлын байр нэмэгдэж, ядуурал буурч, гэр хорооллын дэд бүтэц, амьдрах орчин сайжирч, агаар, орчны бохирдол буурч, төрийн байгууллагуудын засаглал сайжирна гэж тодорхойлсон байна. Байгальд ээлтэй, амьдрахад таатай орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн зохион байгуулах, хэсэгчилсэн дэд бүтцийн төвүүдийг бий болгох, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны хотхонуудыг байгуулах, Налайхын дулаан станцыг өргөтгөх, шинэ эх үүсвэр барих, алслагдсан хороодын дулаан, гэрэлтүүлэг, халуун усыг сэргээгдэх эрчим хүчээр шийдэхийг дэмжих, халаалтын зуухыг халж төвлөрсөн болон хэсэгчилсэн эх үүсвэрт холбох, гэр хорооллын өрхүүдийг сайжруулсан түлшийг бүрэн нэвтрүүлэх, био шахмал түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, сууцны дулаалгыг дэмжих зэрэг арга хэмжээг төлөвлөсөн. Энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр 2028 онд гэхэд гэр хорооллын өрхийг 1.7 дахин багасгана гэж тооцжээ. Агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт хийсэн газрыг суурьшлын бүсэд хязгаарлах, биологийн нөхөн сэргээлт хийлгэх, нөхөөн сэргээлт хийсэн газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч ногоон бүс болгох, хууль бус олборлолтод олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ. Энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр агаарын чанарын үзүүлэлтийг стандарт хэмжээнд хүргэх юм. Ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд халамжийг багасгах, иргэдийн боловсрол, ур чадварыг ахиулах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах, хороодод нийгэм, жендер, гэр бүлийн асуудал хариуцсан хүний нөөцийг бий болгох, амьжиргааны түвшнээс доогуур иргэдэд ажил олгосон байгууллагуудыг дэмжих зэрэг арга хэмжээг авна. Ингэснээр 2028 он гэхэд 1000 өрхийн амьжиргааг дээшлүүлж, ядуу хүн амын тоог 2 дахин бууруулах юм. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгын хүрээнд ажилгүй иргэд болон нүүрс олборлож байгаад ажилгүй болсон иргэдийн хандлагыг өөрчилж, мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулах, шинээр ажлын байр бий болгох, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөр эрхлэх боломжгүй эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон боломжит ажлын байраар хангах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ингэснээр 2028 он гэхэд ажилгүйдлийн түвшинг 2 дахин бууруулах юм. Үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг хөгжүүлэх зорилгын хүрээнд байгальд ээлтэй технологи бүхий аж үйлдвэр, мал ахуй, газар тариалангийн үйлдвэрийг хөгжүүлнэ. Ингэхдээ аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн татвар, эрх зүйн орчныг бий болгох, боловсон хүчнийг хэрэгцээт ажлын байртай нь уялдуулан бэлтгэх, үйлдвэрлэл үйлчилгээг явуулахад шаардлагатай барилга байгууламжууд буюу парк, үйлдвэр, агуулахуудыг барьж байгуулах зэрэг ажлуудыг төлөвлөжээ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр 2028 он гэхэд 10 мянган шинэ ажлын байрыг бий болгоно. Хотын сайн засаглалыг бий болгох зорилгын хүрээнд төрийн байгууллагуудыг ил тод, хариуцлагатай

болгох, ажилтнуудыг чадавхжуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авна. Мөн дүүргийн бодлого, төлөвлөлтийн бүхий л үйл ажиллагаанд бүх төрлийн оролцогч талуудыг оролцуулахаас гадна, жендерийн тэгш байдлыг хангана. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг 2028 он гэхэд 1.4 дахин сайжруулна. Энэ бодлогын хэрэгжилтийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, төлөвлөх, хуваарилах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг дүүргийн “Тогтвортой хөгжлийн зөвлөл” хариуцна. Уг бодлогын зорилт, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг олон төрлийн эх үүсвэрээс буюу төр, хувийн хэвшил, гадаад, дотоодоос хөрөнгө босгох замаар санхүүжилтээр шийдвэрлэнэ.

Налайх дүүргийн дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын сүлжээний 2020-2030 оны мастер төлөвлөгөөг одоо байгаа станц, шугам сүлжээний нөхцөлийг сайжруулах, эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэх, улмаар дүүрэгт хийгдэх бүтээн байгуулалтуудыг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор боловсруулжээ. Уг төлөвлөгөөгөөр 2020-2030 онд 185МВт, 222 мВт-ын хүчин чадалтай 2 дулааны эх үүсвэрийн барилга угсралт, 3-26МВт хүчин чадалтай 15 ком дулаан дамжуулах төв, 16км дулааны шугам сүлжээ, 24 блок угсармал барилгын дулаалгын ажил төлөвлөсөн байна.

3.2.5 JET чиглэлүүдийн хүрээнд нийслэл, дүүргийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа

Дээрх бодлогын баримт бичгүүдэд JET-ийн салбаруудын хүрээнд авч хэрэгжүүлэх дараах гол үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 4 JET-ийн салбаруудын хүрээнд нийслэлийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа

Төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаа	Баримт бичиг
Стратеги	
1. Түгээмэл тархацтай ашигт талтмалын хайгуул, олборлолтыг хотжих бүсэд хязгаарлах, хориглох, эвдэрсэн газрыг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж хөгжүүлэх	УБХЕТ
2. Нийслэлийн сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжсэн татварын хөнгөлөлтийн тогтолцоо бүрдүүлэх	УБХЕТ
Засаглал	
1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд иргэдийн оролцоо, санал хүсэлтийг тусгах механизмыг боловсронгуй болгох	УБХЕТ
2. Хот төлөвлөлтийн үйл ажиллагааны санхүүжилтийн механизмыг сайжруулах	УБХЕТ
3. Хаяа, дагуул хотуудад үйлдвэрлэл үйлчилгээ явуулах хөнгөлөлттэй нөхцлүүдийг тодорхойлж, эрх зүйн орчноор баталгаажуулах	УБХЕТ
4. Нийслэлийн төсвийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог 80%-д хүргэх	НТЖҮЧ
5. Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн аян зохион байгуулах	НТЖҮЧ

6.	Олон нийтийн барилгад эрчим хүчний удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	УБЭХМТ
7.	Шинэ барилгад заавал дагаж мөрдөх эрчим хүчний гүйцэтгэлийн гэрчилгээг нэвтрүүлэх	УБЭХМТ
8.	Эрчим хүчний үр ашгийн шаардлага хангуулах барилгын нормыг шинэчлэх/ мөрдүүлэх	УБЭХМТ
9.	Улаанбаатар хот шинэ барилгыг эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбох заавал дагаж мөрдөх (техникийн хувьд боломжтой тохиолдолд) норм нэвтрүүлэх	УБЭХМТ
Эдийн засаг, аж үйлдвэр		
1.	Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 45%-д хүргэх	УБХЕТ
2.	Мэдлэгт чиглэсэн болон аж үйлдвэрийн кластеруудыг бий болгох	УБХЕТ
3.	Аж үйлдвэрийн паркуудыг их дээд сургуультай хамтад байгуулах	УБХЕТ
Дэд бүтэц, эрчим хүч, түлш		
1.	Дэд бүтцийн хангамжинд сэргээгдэх эрчим хүч, төвлөрсөн буюу хэсэгчилсэн тогтолцоог хослуулан хэрэглэнэ. Мөн дулааны эх үүсвэрүүд нь сэргээгдэх эрчим хүчтэй хосолмол, төрөл бүрийн сайжруулсан түлш байна.	
2.	Хүн амын 30%-ийг хэсэгчилсэн, 70%-ийг төвлөрсөн инженерийн дэд бүтцийн хангамжтай гэр сууц болон орон сууцны хангамжтай байна.	УБХЕТ
3.	375 угсармал орон сууцыг дулаалах	
4.	Нийслэл хотын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 3-4 %-д хүргэх	УБХЕТ
5.	Ахуйн цахилгаан эрчим хүч хэрэглээний 30 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангадаг болох	
6.	2050 онд гэхэд импортын эрчим хүчийг дотоодын сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээс илүү хямд байх тохиолдолд л ашиглах	НТЖҮЧ
7.	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүрт эрдэс түлш ашиглахын оронд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт тулгуурлан гаргаж авсан түлш ашиглах	
8.	2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэх нийт хүчин чадалд тодорхойлсон 30%-тай харьцуулахад 85%-д хүрэх	УБХЕТ
9.	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулалтыг татах, санхүүжилтийг нэмэгдүүлэх таатай орчин бүрдүүлэхийн тулд найдвартай тарифын систем бүрдүүлэх	
10.	2024 он гэхэд Улаанбаатар хот тоолуурын өгөгдөлд суурилсан эрчим хүчний төлбөр тооцоог олон айлын барилгад эхлүүлэх	УБХЕТ
11.	2030 он гэхэд Улаанбаатар хот гэр хорооллын хувийн сууцны үр ашиг багатай нүүрсэн зуух болон ялгарлын стандарт хангахгүй байгаа бүх зуухыг солих	
12.	Улаанбаатар хот олон айлын барилгуудын эрчим хүчний хэрэглээг 2030 он гэхэд 5%, 2040 он гэхэд 15% бууруулах зорилт бүхий шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	УБЭХМТ
13.	Улаанбаатар хот олон нийтийн барилгуудын эрчим хүчний хэрэглээг 2030 он хүртэл 10%, 2040 он хүртэл 20% бууруулах зорилт бүхий шинэчлэлийн хөтөлбөр нэвтрүүлэх	
14.	Улаанбаатар хот гэр хорооллын хувийн сууцнуудын эрчим хүчний хэрэглээг 2030 он гэхэд 22%, 2040 он гэхэд 50% бууруулах зорилт бүхий шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	УБЭХМТ

15.	Улаанбаатар хот CO ₂ , PM, CO, SO ₂ ялгарлыг бууруулах дунд хугацааны зорилтод хүрнэ: 2030 он гэхэд дунджаар 30%, 2040 он гэхэл 60% буурна.	
16.	Боловсруулж сайжруулсан сайн чанарын түлшийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх	УБЭХМТ
17.	Хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслээс нэгж км тутамд ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээг тооцож татвар авах	
18.	Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулсан байна.	УБЭХМТ
19.	Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.	
20.	Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлсэн байна.	УБЭХМТ
Уул уурхай		
1.	Restoration of damaged and polluted land due to mining, sand and gravel extraction	УБХЕТ
Ажлын байр		
1.	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн парк байгуулах, мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнүүдийг бий болгох, дахин төлөвлөлттэй холбогдуулан барилгын салбарын хөгжүүлэх замаар баялаг бүтээх салбаруудад 160 мянган ажлын байрыг бий болгох	УБХЕТ
2.	Ажлын байр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амын 95% хүртэл нэмэгдүүлэх	УБХЕТ

Тайлбар:

1. УБХЕТ - Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
2. НТЖҮЧ - Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
3. УБЭХМТ - Улаанбаатар хотын Эрчим хүчний мастер төлөвлөгөө

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

Хүснэгт 5 JET салбаруудын хүрээнд Налайх дүүргийн хэмжээнд төлөвлөсөн голлох үйл ажиллагаа

Төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаа		Баримт бичиг
Стратеги		
1.	Дүүргийн ТХБББ-т тусгагдсан үйл ажиллагаануудыг ач холбогдлоор эрэмбэлэн томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай бүтээн байгуулалтын ажлуудыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	НДХДХББ
2.	Иргэдэд амьдрах орчныг нь сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, мэдлэг олгох, ОНХС-ийн зарцуулалтад санал өгөх талаар идэвхжүүлэх	НДХДХББ
3.	Дүүргийн ЗДТГ болон Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэсээс санаачлан Засгийн газрын тусгай сангаас хэрэгжүүлэх боломжтой ажлуудын зардлын тооцоог хийж, хамрагдах зорилтот хүрээг тодорхойлж, зардлын төсвийн саналаа Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Ерөнхий Газар болон Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яаманд хүргүүлж ажиллах	НДХДХББ
4.	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, эрүүл мэндийн даатгалын сан, байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтээр дүүргийн ТХБББ-т тусгагдсан үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх боломжийг эрэлхийлж, уг сангуудын үйл ажиллагааг хариуцдаг нийслэл, дүүргийн харьяа агентлаг, хэлтэстэй хамтран ажиллаж, тэдний бодлого төлөвлөлтөд саналаа тусгуулах	НДХДХББ
5.	ТХБББ-т тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардагдах томоохон хөрөнгийг гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх	НДХДХББ
6.	Хувийн хэвшлээс хийгдэж байгаа үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох, илүү шинэлэг, байгальд ээлтэй технологи ашиглах бололцоог олгох, төрөөс энэ чиглэлийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг зохион байгуулах	НДХДХББ
Засаглал		
1.	Хууль бус олборлолтод тавих олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх	НДХДХББ
Дэд бүтэц, эрчим хүч, түлш		
1.	Улаанбаатар бүсийн хот, суурингуудад сэргээгдэх эрчим хүчний 4-өөс доошгүй станц байгуулах	УБХЕТ
2.	Захын бүсийн алслагдмал гэр хорооллын бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий технологийг нэвтрүүлсэн байна.	НТЖҮЧ
3.	Сайжруулсан түлшний 2 дугаар үйлдвэрийг ашиглалтад оруулж, гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	ЗДҮАХ
4.	Дүүргийн гэр хорооллын айл өрхийг халаалтаа дэвшилтэт технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуураар шийдэх боломжийг судалж, гарсан шийдвэр, мэргэжил арга зүйгээр тухай бүр хангаж, өрхийн тоог нэмэгдүүлнэ.	ЗДҮАХ
5.	Гэр хорооллын байшин сууцны дулааны алдагдлыг бууруулах олон талт арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	ЗДҮАХ
6.	Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.	ЗДҮАХ

7.	Налайхын Дулааны станцад өргөтгөл шинэчлэл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	ЗДҮАХ
8.	Дулааны гол магистраль шугамын үрт, дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.	ЗДҮАХ
9.	Хатуу түлшний халаалтын зуухны тоог төвлөрсөн дулаанд холбох, хийн түлшинд шилжүүлэх замаар үе шаттайгаар багасгана.	ЗДҮАХ
10.	Хэрэгцээний халуун ус хангамжийг холигч дээрх хурдан ус халаагч, нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүч ашиглан хэрэглэх	НД ХЕТ
11.	Дулааны эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх эдийн засгийн сонирхол төрүүлэх төлбөр тооцоо, үнэ тарифын тогтолцоог бий болгох	НД ХЕТ
12.	Гэр хороололд хэсэгчилсэн дэд бүтцийн төвүүдийг бий болгон, нам давхрын болон хувийн орон сууцны хорооллыг хөгжүүлэхэд иргэдийн оролцоог хангана	НДХДХББ
13.	Амины ногоон орон сууц төслийг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, цэвэр технологи шингэсэн орон сууцны хотхон байдлаар төлөвлөж, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хөгжүүлнэ.	НДХДХББ
14.	Налайхын дулааны станцыг өргөтгөх, шинэ эх үүсвэр барих төслийг хэрэгжүүлж гэр хорооллын өрхийг найдвартай эх үүсвэрээр хангана.	НДХДХББ
15.	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр (нар, салхи, газрын гүний ус, дулаан)-ийн технологийн судалгааг дэмжиж, алслагдсан хороодын дулаан, гэрэлтүүлэг, халуун усны хэрэглээг байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологиор шийдэхийг дэмжинэ.	НДХДХББ
16.	Халаалтын зуухнуудыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн болон хэсэгчилсэн эх үүсвэрт холбоно.	НДХДХББ
17.	Гэр хорооллын өрхөд сайжруулсан түлшийг бүрэн түгээж, нөөц бий болгож, тасралтгүй худалдан авах боломжоор хангана.	НДХДХББ
18.	Био, шахмал түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, айл өрхөд нийлүүлэх ажлыг зохион байгуулна.	НДХДХББ
19.	Гэр, байшин сууцны дулаалга хийхэд дэмжлэг үзүүлэх, оршин суугчдыг сургах, мэдлэг олгох ажлыг зохион байгуулна.	НДХДХББ
Эдийн засаг, аж үйлдвэр		
1.	Мах, дайвар бүтээгдэхүүний төрөлжсөн агуулах барих	УБ ХЕТ
2.	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаль орчинд сөрөг нөлөөлөл өндөртэй, үйлдвэрлэлүүдийг хориглох бөгөөд одоо байгаа ийм төрлийн үйлдвэрүүдийг дагуул Багануур, Багахангай, Налайх, Аргалант-Эмээлт хотууд руу нүүлгэн шилжүүлнэ.	УБ ХЕТ
3.	Налайх дүүргийг хаяа хот болгож үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, соёл урлаг, боловсролын чиглэлээр хөгжүүлэхээр тусгагдсан. Үүнд Хүнс, хөнгөн үйлдвэрлэл. /Өөрийн хотын хэрэгцээг бүрэн хангах / - Технологи нутагшуулах парк - Аялал жуулчлалын салбар – Жижиг, дунд үйлдвэрлэл - Тээвэр ложистик, томоохон агуулахын аж ахуй (Логистик төвийг байгуулах) - Барилгын материалын үйлдвэрлэл, бөөний худалдаа - Утаагүй түлшний үйлдвэрлэл - Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв - Шинэ технологи нутагшуулах парк - Улсын чанартай томоохон эмнэлгийн цогцолбор - Өрхийн аж ахуй / тенент парк / жижиг дунд үйлдвэрлэл	УБ ХЕТ
4.	Налайхын логистикийн нэгдсэн төвүүдээс хөдөө, орон нутаг руу, хотын доторх түгээлтийн төвүүд рүү болон томоохон хэрэглэгч, үйлдвэрлэгч рүү чиглэсэн	УБ ХЕТ

	маршрутын дагуу ачаа тээврийг үйл ажиллагаа явагдах бөгөөд хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих зориулалттай тусгай замыг байгуулна.	
5.	Логистикийн төв байгуулна.	УБ ХЕТ
6.	Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк байгуулах	УБ ХЕТ, НТЖҮЧ
7.	Төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмэгдүүлж орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын алдагдлыг бууруулж төсвийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	ЗДҮАХ
8.	Нийслэлээс авах санхүүгийн дэмжлэгийг бууруулж, Татварын орлогыг өмнөх оноос нэмэгдүүлэн, өрийн үлдэгдлийг бууруулж төсвийн тухай хуульд заасан шалгуурыг хангаж ажиллана.	ЗДҮАХ
9.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн бойжигч болон өрхийн үйлдвэрлэл эрхэгч иргэдийг мэдээллээр хангах, сургалтад хамруулах, үйлдвэрлэл явуулах ажлын байртай болгох, санхүүгийн болон шаардлагатай тоног төхөөрөмжийн туслалцаа, олон талт дэмжлэг үзүүлэх ажлыг судлан бодлогоор дэмжиж ажиллана.	ЗДҮАХ
10.	Налайх дүүрэгт 180 га газарт авто, төмөр замын терминал, түлш шатахууны агуулахууд төрөл бүрийн бөөний худалдаа бүхий ложистикийн төв байрлахаар төлөвлөсөн.	НД ХЕТ
Уул уурхай		
1.	Уул уурхайн нөхөн сэргээлт хийгдсэн газруудыг орон нутаг тусгай хамгаалалтад авч ногоон бүс болгон тохижуулах, хууль бус олборлолт дахин хийлгэхгүй талаар олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ.	ЗДҮАХ
2.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын ашиглалтын байдалд хяналт тавьж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг заавал хийлгэдэг болгоно.	ЗДҮАХ
3.	Уул уурхайн улмаас эвдрэл доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгон эргэлтэд оруулж ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.	ЗДҮАХ
4.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтыг суурьшлын бүсэд хязгаарлан, биологийн нөхөн сэргээлтийг заавал хийлгэдэг болгоно.	НДХДХББ
5.	Уурхайн нөхөн сэргээлт хийгдсэн газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, ногоон бүс болгон тохижуулна.	НДХДХББ
Ажлын байр		
1.	Ядуурлын түвшинг 18.4%, ажилгүйдлийн түвшинг 5% болгож бууруулна.	УБ ХЕТ
2.	Их, дээд сургуулиудын хотхон: Улаанбаатар хотоос их дээд сургуулиудын зарим хэсгийг сургалтын чиглэлээр нь дараах хаяа дагуул хотуудад “Их сургуулийн хотхон” байгуулах замаар нүүлгэн шилжүүлэн байршуулна. - Багануур - Налайх	УБ ХЕТ
3.	2025 онд Налайх дүүрэгт хөдөлмөрийн насны 28,300 хүн байхаас 16,000 нь хөдөлмөр эрхлэнэ, 2040 онд хөдөлмөрийн насны 52,900 хүн байхаас 30,000 нь хөдөлмөр эрхлэнэ гэж тооцоолжээ.	УБ ХЕТ
4.	2040 он хүртэл ажлын байрыг 29,970 болгож нэмэгдүүлнэ гэж тооцоолжээ.	УБ ХЕТ

5.	Ажлын байрны талбай 2020 оны байдлаар 165,000 м2 байна. Үүнийг 2040 он гэхэд 1.5 сая м2 шинэ ажлын байр барих бөгөөд түүний 47%-ийг үйлдвэр, 51%-ийг үйлчилгээ, 2%-ийг ХАА-н зориулалттай байхаар төлөвлөжээ.	УБ ХЕТ
6.	Төмөр зам, Барилгын материал, үйлдвэр технологийн парк, Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр зэрэг үндэсний хэмжээний уул уурхай, барилга, бүтээн байгуулалтын төслүүдэд иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлан хамруулж, зохистой хөдөлмөрт шилжүүлэн ажилгүйдлын түвшинг бууруулна.	ЗДҮАХ
7.	Томоохон бүтээн байгуулалт болон дүүргийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, төрөлжүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангагдахад дэмжлэг үзүүлнэ.	ЗДҮАХ
8.	Логистикийн төв байгуулснаар 3,500 орчим, барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк байгуулснаар 1,950, барилгын материалын худалдан борлуулах төв байгуулснаар 3,000 ажлын байр шинээр бий болно гэж тооцоолсон.	НД ХЕТ
9.	Ядуу өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнд олгох халамжийг багасгаж, тэдний ухамсар, зан төлөв, хандлага, амьдралын итгэл үнэмшлийг өөрчлөх хөтөлбөрт хамруулж, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэнэ.	НДХДХББ
10.	Ядуу өрхийн боловсролын түвшин доогуур ажил эрхэлдэггүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг суурь боловсрол, мэргэжлийн боловсрол болон мэргэжил эзэмшүүлэх, үр чадварыг ахиулах сургалтад хамруулна.	НДХДХББ
11.	Хорооны гэр бүлийн хөгжил, нийгмийн халамжийн асуудал хариуцсан ажилтнуудад жендэрийн мэдрэмжтэй зөвлөх үйлчилгээний арга зүйг эзэмшүүлнэ.	НДХДХББ
12.	Суурь боловсрол эзэмшээгүй насанд хүрэгчдийг ерөнхий боловсрол олгох Албан бус боловсролын төв, МСҮТ-д суралцуулах зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ	НДХДХББ
13.	Хууль бусаар нүүрс олборлож буй иргэдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилгоор олборлолтын шаардлага хангахгүй уурхайн хэсгийг бүрэн хааж, талбайг нөхөн сэргээж, аюулгүй орчин бүрдүүлнэ	НДХДХББ
14.	Уурхайд ажиллаж байгаад ажлын байргүй болсон иргэдийг сургалтад хамруулан тэдний хандлага, дадал, зуршлыг өөрчлөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хөдөлмөрлөх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлнэ	НДХДХББ
15.	“Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	НДХДХББ
16.	“Сайжруулсан шахмал түлшний хоёр дахь үйлдвэр”-ийг шинээр барьж байгуулах, уг үйлдвэрт ажиллах хүчний нөөцийг Налайх дүүргийн оршин суугчдаас бүрдүүлнэ.	НДХДХББ
17.	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон холбогдох сургалтын байгууллагатай хамтран ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ажил, мэргэжлээр сургах ажлыг зохион байгуулна.	НДХДХББ
18.	Өрхийн үйлдвэрлэл эрхлэх замаар өөрөө өөртөө ажлын байр бий болгож байгаа иргэдийг мэдээллээр хангах, сургалтад хамруулах, үйлдвэрлэл явуулах ажлын байраар хангах, санхүүгийн болон шаардлагатай тоног төхөөрөмжийн	НДХДХББ

туслалцаа үзүүлэх, орон нутгийн онцлогт нийцсэн жишиг үйлдвэрийг бий болгоход олон талт дэмжлэг үзүүлнэ.

-
19. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бага насны хүүхдээ гэрээр асарч бүтэн цагийн хөдөлмөр эрхлэх боломжгүй байгаа эмэгтэйчүүдийг хагас цагаар ажиллуулах боломжийг бүрдүүлэх ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран зохион байгуулна. НДХДХББ
-

Тайлбар:

1. УБХЕТ - Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
2. НТЖҮЧ - Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
3. УБЭХМТ - Улаанбаатар хотын Эрчим хүчний мастер төлөвлөгөө
4. ЗДҮАХ - Налайх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
5. НДХДХББ - Налайх дүүргийн Тогтвортой хөгжлийн дүнд хугацааны бодлогын баримт бичиг
6. НД ХЕТ - Налайх дүүргийн 2015-2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

IV. НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ эрчим хүчний зохистой шилжилтийн стратеги

4.1 Алсын хараа

Налайх нь тогтвортой, ногоон үйлдвэрлэл дээр тулгуурласан ногоон хөгжлийн жишиг дүүрэг (дагуул хот) болно.

4.2 Эрхэм зорилго

Эрчим хүчний зохистой шилжилтийн механизмд тулгуурлан ногоон эдийн засаг, зохистой ажлын байр, сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлж, Налайх дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

4.3 Стратегийн зорилтууд

Налайх дүүргийн Зохистой эрчим хүчний шилжилтийн стратегийг дараах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах

Зорилт 2. Нүүрсний уурхайн экологийн нөхөн сэргээлтийг хийж шинэ бүтээн байгуулалтыг дэмжих

Зорилт 3. Зохистой ногоон хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгох

Зорилт 4. Нүүрст суурилсан эрчим хүчний системийг хүлэмжийн хийн ялгарал багатай систем рүү үе шаттайгаар шилжих

Зорилт 5. Зохистой эрчим хүчний шилжилтийн стратегийг хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх

V. үйл ажиллагааны төлөвлөгөө

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах

- 1.1. Инновацид суурилсан байгальд ээлтэй технологи бүхий аж үйлдвэр, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 1.2. Бизнес эрхлэхэд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлж, сайжруулна
- 1.3. Ногоон бизнес эрхлэгчдийг дэмжих, ЖДҮ-ийг дэмжих
- 1.4. Бизнес инкубаторын хөтөлбөр, менторшип, санхүүжилтийн боломжууд үүсгэх замаар бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, боломжит нөөцөөр хангах.
- 1.5. Дүүргийн бодлого, үйл ажиллагааг илүү оновчтой болгох, хүнд суртлыг багасгах, зах зээлд нэвтрэх боломжийг бүх талаар хөнгөвчлөх замаар бизнесийн таатай орчныг бүрдүүлэх
- 1.6. Дүүргийн эдийн засагт дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд дүүргийн онцлог давуу тал, өрсөлдөх чадварыг тодорхойлж сурталчлах замаар хөрөнгө оруулалтыг дэмжих кампанит ажил, санаачилгыг хөгжүүлэх.
- 1.7. Мэдлэгт суурилсан болон аж үйлдвэрийн кластеруудыг бий болгох
- 1.8. Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч гаргах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга технологи нэвтрүүлэх.

Зорилт 2. Нүүрсний уурхайн экологийн нөхөн сэргээлтийг хийж шинэ бүтээн байгуулалтыг дэмжих

- 2.1. Уурхайн хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн суурь бүтэц байдлаар ашиглах
- 2.2. Эко аялал жуулчлал, уурхайн музей байгуулах, хөдөө аж ахуй, судалгаа хөгжлийн төв гэх мэт тогтвортой хөгжлийн зорилгоор нүүрсний уурхайн газрыг дахин ашиглах
- 2.3. Уурхайд ажиллаж байсан иргэдэд дэмжлэг үзүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх
- 2.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтыг хотжих бүсэд хязгаарлах, хориглох, эвдэрсэн газрыг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж хөгжүүлэх

Зорилт 3. Зохистой ногоон хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгох

- 3.1. Хөрөнгө оруулалт татах замаар бизнес эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх
- 3.2. Ажиллах хүчний нөөцийг нэмэгдүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, хамтын ажиллагааны сүлжээг бэхжүүлнэ
- 3.3. Ногоон ажлын байрны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, инновацийг дэмжих
- 3.4. Ногоон ажлын байр бий болгохыг дэмжих, ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх
- 3.5. Хөдөлмөрийн зохистой нөхцөл бүрдүүлж, нийгмийн хамгааллыг хангана
- 3.6. Бага орлоготой өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнд олгох халамжийг багасгаж, тэдний хандлагыг өөрчлөх хөтөлбөрт хамруулж, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэнэ.
- 3.7. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн болон тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, ажил олгогч болон хөгжих тал дээр дэмжих
- 3.8. Иргэдэд цагийн ажил хийх боломж нөхцлийг бүрдүүлэх

Зорилт 4. Нүүрсэд суурилсан эрчим хүчний системийг хүлэмжийн хийн ялгарал багатай систем рүү үе шаттайгаар шилжих

- 4.1. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ
- 4.2. Эрчим хүч, дулааны хэмнэлтийг сайжруулах, гэр, байшин барилгын дулаан алдагдлыг бууруулах
- 4.3. Эрчим хүч, дулааны дэд бүтцийг шинэчлэх, ухаалаг сүлжээг хөгжүүлэх, Гэр хороололд дулаан, цэвэр бохир усны төвлөрсөн дэд бүтэц байгуулах ажлыг эрчимжүүлж, гэр хорооллын нийт өрхийг төвлөрсөн дэд бүтцэд хамруулах
- 4.4. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах
- 4.5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулах
- 4.6. Хатуу түлшний халаалтын зуухыг цөөлж, хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг байгуулах замаар ялгарлыг бууруулах
- 4.7. Хэрэгцээний халуун ус хангамжийг төвлөрсөн системээс бус, бие даасан түргэн халаагч болон сэргээгдэх эрчим хүч ашиглан хангах
- 4.8. Үр ашиг өндөртэй шахмал болон био түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 4.9. Зарим байгууллага, аж ахуйн нэгжийг хэрэглээндээ сэргээгдэх эрчим хүч хэрэглэхийг дэмжих
- 4.10. Төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж яндангийн тоог бууруулах

Зорилт 5. Зохистой эрчим хүчний шилжилтийн стратегийг хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх

- 5.1. Зохистой эрчим хүчний шилжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах
- 5.2. Цэвэр болон сэргээгдэх эрчим хүчний шилжилтэд иргэдийн оролцоог бий болгох
- 5.3. Иргэд гэр сууцаа байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, цэвэр технологи шингэсэн арга хэлбэрээр барьж байгуулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- 5.4. Шатахууны түлшнээс татгалзаж, нүүрстөрөгч багатай, цахилгаанаар ажилладаг автотээврийг хөгжүүлэх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх
- 5.5. Зохистой эрчим хүчний шилжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд үүрэг хүлээсэн төрийн алба хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, стратегийн хэрэгжилт болон бодлогын баримт бичгийн залгамж халааг хангах
- 5.6. Эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, утаа, замын түгжрэлийг аль алиныг нь бууруулахын тулд явган алхах, дугуй унах зэргийг дэмжих

Стратегийг хэрэгжүүлэх үе шат, хугацаа

Стратегийг жилийн хугацаанд дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

I үе шат: 2024-2025 он – Энэ шатны төлөвлөгөөг энэхүү стратегид тусгасан бөгөөд Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөнд санал болгоно.

II үе шат: 2025-2030 он – Энэ шатны төлөвлөлтийг энэхүү стратегигээс сонгон авч Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж ажиллана.

III үе шат: 2030-2040 он – Энэ шатны төлөвлөлтийг өмнөх шатуудын хэрэгжилтийг дүгнэж, сайжруулан, Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд тусгаж ажиллана.

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ЗОХИСТОЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОГИНО ХУГАЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТУСТАХ САНАЛ

Д/д	Дүүргийн Засаг даргын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжээх нэгж	Үр дүнгийн		2024 оны шаардлагатай хөрөнгө		Хэрэгжүүлэх байгууллага	
				Суурь түвшин	Зорилгот түвшин	Санхүүжилтийн хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Үндсэн	Хамтрагч
1.	1.5.2.4.Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зохиистой хөдөлмөрт шилжүүлэх дүүргийн онцлолт тохирсон хувиараа болон өрхийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгч, баялаг бүтээгчдэд чиглэсэн арга хэмжээг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. 2.1.3.1.Хөрөнгийн	Уурхайд ажиллаж байсан иргэдийг зохиистой хөдөлмөрт шилжүүлэх, даван сургах	хамрагдсан хүний тоо	15	30	2 сая	тусгай сангаар	ХХҮХ	Налайх ПТК
2.	удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтыг татварын бодлого, төрийн үйлчилгээний бусад нөхцөлөөр татах боломжийг бий болгох тогтолцоог судлана. 2.2.3.1.Жижиг, дунд	Дүүргийн эдийн засаг дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд дүүргийн онцлог давуу тал, өрсөлдөх чадварыг тодорхойлж сурталчлах замаар хөрөнгө оруулалтыг дэмжих кампанит ажил, санаачилгыг хөгжүүлэх.	үйл ажиллагааны тоо	0	2	0	0	ЗДТГ	ОУБайгууллага
3.	үйлдвэрлэлийг дэмжих төвийн бийжигч болон өрхийн үйлдвэрлэл эрхэгч иргэдийг нэдээллээр хангах, сургалтад хамруулах, үйлдвэрлэл явуулах ажлын байртай болгох, санхүүгийн болон шаардлагатай тоног	ЖДҮ эрхлэгчдэд ногоон бизнесийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх	хамрагдсан хүний тоо	0	50	1 сая	тусгай сангаар	ЖДҮД төв	ХХҮХ

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

Стратегийн зорилт, үйл ажиллагааг улс, нийслэл, дүүргийн төсөв, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт гэсэн 4 эх үүсвэрээр шийдвэрлэнэ. Үүнд:

Санхүүжилтийн эх үүсвэр		Санхүүжүүлэх нөхцөл, шаардлага
Төсөв	Улс	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн чиг үүрэгтэй холбоотой хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт (нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр) болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар (нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн)-д тусгасны үндсэн дээр улсын төсвөөс санхүүжүүлж болно.1 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх боломжтой. 3 Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.4
	Нийслэл	<ul style="list-style-type: none"> Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болно. 5
	Дүүрэг	
	Орон нутгийн хөгжлийн сан ОНХС	<ul style="list-style-type: none"> ОНХС нь тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг. 6 Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.7 Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр дүүргийн иргэдээр дэмжигдсэн дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төслийг санхүүжүүлэх боломжтой.8

		<ul style="list-style-type: none"> • Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан, орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдсэн төслүүдийг хэрэгжүүлнэ. 9
Засгийн газрын тусгай сангууд	Байгаль орчин, уур амьсгалын сан	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой.10 • Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах11
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	<ul style="list-style-type: none"> • Аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс дэд санд хуваарилсан хөрөнгийг тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан чиглэл, зорилтот арга хэмжээнд зарцуулна.12
	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	<ul style="list-style-type: none"> • Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох13
Гадаадын зээл, тусламж	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	<ul style="list-style-type: none"> • Үндэстэн дамжсан корпорациуд
	Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламж болон төсөл хөтөлбөрийн санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Япон Улс, БНХАУ, ХБНГУ зэрэг орнуудын хөтөлбөр, төсөл, зээл тусламжийг авах боломжтой.14 • Стратегийн зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай томоохон ажлуудын санхүүжилтийг гадаадын зээл, тусламжаар шийдвэрлэх боломжийг судалж, хэрэгжүүлнэ
	Ногоон санхүүжилт	<ul style="list-style-type: none"> •
Төр, хувийн хэвшлийн түншлэл ба хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшлийг үйл ажиллагаа явуулах бодлого, эрх зүй, нөхцөлөөр хангах, иргэд, хувийн хэвшлийн оролцоог дээшлүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд ил тод байлгах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг зорилт, үйл ажиллагаанд оролцоог нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татах
	Төр, хувийн хэвшлийн түншлэл	<ul style="list-style-type: none"> • Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад үндэслэн дэд бүтцийг байгуулах, засвар үйлчилгээ үзүүлэх, нийтэд зориулсан төрийн үйлчилгээг гүйцэтгүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, инноваци, шинэ технологийг нэвтрүүлэх боломжтой, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн байна.
	Монгол Улсын банкуудын Тогтвортой санхүүжилт, Ногоон зээлийн сан	<ul style="list-style-type: none"> • Арилжааны банкуудаас ногоон зээл авах боломжийг судлах
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив тусламж	

VI. Хяналт Үнэлгээний Төлөвлөгөө

Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		
			2022 он	2025	2030	2040
Зорилт 1. Орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах						
	Уул уурхайн бус салбаруудын дүүргийн эдийн засагт эзлэх хувь	Дүүргийн эдийн засагт эзлэх хувь				
	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуй Газар тариалан Аялал жуулчлал Ложистик, тээвэр Үйлдвэр Худалдаа, үйлчилгээ 		5%	7%	10%	15%
			-	-	-	-
			33%	33%	35%	40%
			30%	-	-	-
			-	25%	25%	30%
			20%	35%	30%	15%
			30%			
	Дүүрэгт хэрэгжихээр төлөвлөсөн үйлдвэржилтийн төслүүд		3	6	16	46
	Ногоон бизнес эрхлэгчдийн тоо		12	50	115	200
	ЖДҮ-ийн тоо		366	400	470	550
Зорилт 2. Нүүрсний уурхайн экологийн нөхөн сэргээлтийг хийж шинэ бүтээн байгуулалтыг дэмжих						
	Нүүрсний уурхайн экологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай		142,3	100	95,7	
	Тусгай хамгаалалтад авсан уул уурхайн нөхөн сэргээлтийн газар		100	100		
	Уурхайн нөхөн сэргээлт хийгдсэн газруудыг ногоон бүс болгон тохижуулсан талбай		45,8	20	50	50
	Нөхөн сэргээлт хийгдсэн газар дээр хийсэн нийт шинэ бүтээн байгуулалт		0	2	3	5
Зорилт 3. Зохистой ногоон хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгох						
	Шинээр бий болгосон ажлын байр	Тоо	150	170	170	180
	Зохистой, ногоон ажлын байр	Тоо	0	25	125	250
	Хуучин уурхайн ажилчдыг даван сургах, шинэ мэргэжил эзэмшүүлэх	Тоо	15	30	40	
Зорилт 4. Нүүрст суурилсан эрчим хүчний системийг хүлэмжийн хийн ялгарал багатай систем рүү үе шаттайгаар шилжих						
	Сэргээгдэх эрчим хүчний эрчим хүчний эх үүсвэрт эзлэх хувь	Хувь	0	5	30	40
	Дулааны шугам сүлжээнд холбогдсон айл	Өрхийн тоо	3100	3400	3800	4800
	Сэргээгдэх эрчим хүч ашиглаж буй айл	Өрхийн тоо	50	100	200	700
	Цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх станцын тоо	Тоо	0	1	5	20

Нийтийн тээврийг цахилгаан тээврийн тоо хэрэгслээр орлуулах	0	5	10	15
Дулаалга хийгдсэн олон Барилгын тоо айлын барилга	31	38		
Гэр хороололд дулаалга хийсэн Байшингийн тоо байшин	1200	1320	1900	4800
Дулаан техникийн шинэчлэлд төсөлд Барилгын тоо хамрагдсан нийтийн зориулалттай барилга	3	5	13	

Зорилт 5. Зохистой эрчим хүчний шилжилтийн стратегийг хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түлгүүрлэн хэрэгжүүлэх

Зохистой эрчим хүчний шилжилтийн тоо төсөлд хамрагдсан иргэд	0	100	500	3500
Зохистой эрчим хүчний шилжилтийн тоо нөлөөллийн ажлуудад оролцсон иргэд	0	385	3385	33385
Төрийн хувийн хэвшлийн түншлэлийн Тоо хүрээнд хэрэгжсэн төсөл	0	2	11	31
Төсвийн бус хөрөнгө оруулалтаар Нийт төсөв эзлэх хэрэгжсэн төслийн хэмжээ хувь	0	5	10	30

Эх сурвалж: Зохиогчийн хүснэгт

Стратегийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Стратегид туссан богино, дунд, урт хугацааны үйл ажиллагаануудыг дүүргийн бодлогын баримт бичгүүдэд тусгах, төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа, шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшил, иргэний хамтын үйл ажиллагааг уялдуулах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах, төлөвлөх, хуваарилах, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс хариуцна.

Стратегийн богино хугацааны арга хэмжээ буюу дүүргийн тухайн оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлд тусгах, дунд хугацааны арга хэмжээг дүүргийн салбарын хөгжлийн хөтөлбөрүүд болон дүүргийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах асуудлыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс тус тус хариуцна.

Стратегийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжүүлэх үүргийг дүүргийн Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх байгууллагууд болох Газар зохион байгуулалтын алба, Дулааны станц, Эрчим хүчний түгээх төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс зэрэг холбогдох байгууллагууд хариуцан ажиллана.

Just Energy Transition in Coal Regions